

**ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2026 оны 06 дугаар сарын 09-ний өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-6
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	7-32

- 1. Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.03.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/** 7-26
 - 2. Эрүүл мэндийн салбарын санхүүжилт, эмийн үнэ, хүний нөөц, цалин хөлсний талаарх Эрүүл мэндийн сайдын мэдээллийг сонсох** 27-32
-

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны
06 дугаар сарын 09-ний өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дарга П.Ганзориг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 30 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 53.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 11 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Галбадрах, Л.Энхнасан;
Чөлөөтэй: Н.Алтаншагай, О.Батнайрамдал, Ж.Баясгалан, Ц.Мөнхтуяа;
Эмнэлгийн чөлөөтэй: Б.Түвшин.

Нэг.Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.03.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Даваажаргал, мөн яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга В.Рэнцэнханд, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал, Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны гишүүн, дэд дарга Т.Цэрэнбадрал, мөн хорооны Даатгалын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч З.Батболд, Үнэт цаасны газрын ахлах зөвлөх А.Нинжин, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Ж.Мөнх-Оргил нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, зөвлөх Б.Мажигсүрэн, референт Б.Цогзолбаяр нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, П.Наранбаяр, М.Нарантуяа-Нара нарын тавьсан асуултад Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал, Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны гишүүн, дэд дарга Т.Цэрэнбадрал нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, П.Наранбаяр, Г.Хосбаяр, Д.Энхтуяа, Д.Ганмаа, М.Нарантуяа-Нара, Х.Болормаа, П.Ганзориг нар үг хэлэв.

П.Ганзориг: Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 7

Бүгд: 23
69.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

1.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 7
Бүгд: 23
69.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 8
Бүгд: 23
65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 7
Бүгд: 23
69.6 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 7
Бүгд: 23
69.6 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 7
Бүгд: 23
69.6 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 7
Бүгд: 23
69.6 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 7
Бүгд: 23
69.6 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 7
Бүгд: 23
69.6 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 7
Бүгд: 23
69.6 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 7
Бүгд: 23
69.6 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 7
Бүгд: 23
69.6 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 7
Бүгд: 23
69.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 21 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Эрүүл мэндийн салбарын санхүүжилт, эмийн үнэ, хүний нөөц, цалин хөлсний талаарх Эрүүл мэндийн сайдын мэдээллийг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Эрдэнэбаяр, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Туяа, Санхүү, эдийн засгийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Л.Мөнхцэцэг, Эрүүл мэндийн даатгалын бодлого зохицуулалтын газрын дарга Д.Отгонбаатар, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга Ц.Батбаатар, мөн газрын Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын дарга П.Алтанцэцэг, Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын ахлах мэргэжилтэн Ш.Энхтуяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, зөвлөх Б.Мажигсүрэн, референт Б.Цогзолбаяр нар байлцав.

Эрүүл мэндийн салбарын санхүүжилт, эмийн үнэ, хүний нөөц, цалин хөлсний талаарх мэдээллийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн Т.Мөнхсайхан мэдээлэлтэй холбогдуулан Эрүүл мэндийн сайд хуралдаанд байлцах шаардлагатай тул уг асуудлыг хойшлуулах горимын санал гаргав.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен үг хэлэв.

П.Ганзориг: Улсын Их Хурлын гишүүн Т.Мөнхсайханы гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 8
Бүгд: 23
65.2 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн тул Эрүүл мэндийн салбарын санхүүжилт, эмийн үнэ, хүний нөөц, цалин хөлсний талаарх Эрүүл мэндийн сайдын мэдээллийг хойшлуулав. /15:40/

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 29 минут үргэлжилж, 30 гишүүнээс 23 гишүүн хүрэлцэн ирж, 76.7 хувийн ирцтэйгээр 15 цаг 40 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ХҮНИЙ ХӨГЖИЛ,
НИЙГМИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

П.ГАНЗОРИГ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ГАЗРЫН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

П.Ганзориг: Гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Байнгын хорооны ирвэл зохих 30 гишүүнээс 16 гишүүн ирж, 53 хувийн ирцтэй ингээд болсон тул байнгын хорооны 2026 оны 06 дугаар сарын 09-ний хуралдааныг нээснийг мэдэгдье.

Өнөөдрийн Байнгын хорооны хурлаар 2 асуудал хэлэлцэнэ. Хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1 дүгээрт, Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 03 дугаар сарын 18-ны өдөр өргөн мэдүүлсэн. Энийг бид нар хэлэлцэх эсэхийг нь шийдвэрлэнэ.

2-т, Эрүүл мэндийн даатгалын салбарын санхүүжилт, эмийн үнэ, хүний нөөц, цалин хөлсний талаарх Эрүүл мэндийн сайдын мэдээллийг сонсоно.

Ингээд хэлэлцэх асуудалтай холбоотой өөр саналтай гишүүн байна уу. Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Засгийн газар 2026 оны 03 дугаар сарын 18-ны өдөр өргөн мэдүүлсэн Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцье.

Ингээд хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг Засгийн газрын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Аубакир танилцуулна. Ажлын хэсгийн гишүүдийг оруулъя.

Т.Аубакир: Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын хөгжлийн урт, дунд хугацааны бодлого, хөтөлбөрт тэтгэврийн даатгалыг олон давхар тогтолцоонд шилжүүлэх, тэтгэврийн тогтолцоонд хувийн хэвшлийн оролцоог сайн дурын нэмэлт хэлбэрээр дэмжин, ахмад настан, олон эх үүсвэр бүхий тэтгэврийн орлоготой байх нөхцөлийг бүрдүүлэх, даатгуулагчийг илүү олон жил хөдөлмөрлөж, шимтгэл төлөхийг урамшуулах, санхүүгийн зах зээлийг дэмжих зорилт дэвшүүлсэн.

Түүнчлэн, хүн амын насжилт, дундаж наслалтын өсөлтөөс үүдэлтэй хөдөлмөр эрхлэх хугацаа уртсаж байгаатай холбогдуулан иргэд цалин орлоготой байх үедээ бүрэн хуримтлал бүхий хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцоонд сайн дурын үндсэн дээр хамрагдах, ирээдүйд зөвхөн улсын тэтгэврийн даатгалын сангаас гадна нэмэлт эх үүсвэрээс тэтгэвэр авах сонирхолтой байна.

Хувийн тэтгэврийн хуримтлалд хамрагдах иргэдийн оролцоо нэмэгдэж байгаа хэдий ч Монгол Улсад энэхүү харилцааг зохицуулсан хууль, эрх зүйн орчин бүрдээгүй байна. Энэ нь хувийн тэтгэврийн тогтолцоонд хамрагдаж байгаа иргэдийн эрх зөрчигдөх эрсдэлтэй байна.

Иймд дээрх тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилгоор Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ болон бусад хууль тогтоомжтой нийцүүлэн холбогдох талуудын оролцоог ханган 11 бүлэг 49 зүйлтэйгээр шинэчлэн боловсрууллаа.

Хуулийн төсөл батлагдсанаар ажил олгогчид, ажилчдынхаа нийгмийн хамгааллыг дэмжсэн хүний нөөцийн бодлого хэрэгжүүлэх, чадварлаг ажилтныг тогтвор суурьшилтай ажиллуулах, байгууллагын нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэх, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх боломж бүрдэх юм.

Түүнчлэн даатгал тэтгэврийн сангуудын хөрөнгийн хэмжээ өсөж, урт хугацаанд дотоодын хөрөнгө оруулалтын эх үүсвэр нэмэгдсэнээр санхүүгийн зах зээлийн хөгжилд эерэг нөлөө үзүүлнэ гэж үзэж байна.

Иргэд хувийн нэмэлт тэтгэврийн хуримтлалаасаа өөрөө сонгож, 1 удаа 5-10 жилийн хугацаанд мөн насан туршдаа тэтгэвэр авах боломжтой болно. Мөн иргэн тэтгэврийн наснаас өмнө хөдөлмөрийн чадвараа алдсан тохиолдолд тэтгэвэр тогтоолгох эрхтэй бөгөөд нас барсан бол тэтгэврийн хуримтлалаа өвлүүлэх зохицуулалтыг мөн тусгалаа.

Иймд Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг хэлэлцэн дэмжиж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

П.Ганзориг: Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнууд, ажлын хэсгийн таницуулъя. А.Даваажаргал Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга, В.Рэнцэнханд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн газрын дарга, Б.Батжаргал Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга, Т.Цэрэнбадрал Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны гишүүн, дэд дарга, З.Батболд Санхүүгийн зохицуулах хорооны Даатгалын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, А.Нинжин Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын ахлах зөвлөх, Ж.Мөнх-Оргил Санхүүгийн зохицуулах хорооны Хууль, эрх зүйн газрын дарга гэсэн ийм бүрэлдэхүүнтэй байна. Сангийн яамнаас алга байна.

Хэлэлцэж байгаа асуудалтай, танилцуулгатай холбоотой асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Нарантуяа-Нара гишүүнээр тасаллаа. Аюушийн Ариунзаяа гишүүн асуултаа асууя.

А.Ариунзаяа: Би ч өөрөө сайдаар ажиллаж байхдаа 5 хууль өргөн барьж байсан. Тэгээд 1 нь үлдээд, одоо л орж ирж байна шүү дээ. Хувийн нэмэлт тэтгэврийн тухай.

Нийгэмд 1 дүгээрт маш ойлгомжтой хэлэх ёстой асуудал нь юу вэ гэхээр энэ яг одоо тэтгэвэр авч байгаа хүмүүст ямар ч нөлөөлөл үзүүлэхгүй. 1 дүгээрт.

2 дугаарт хувийн нэмэлт тэтгэвэр гэдэг маань өөрөө өнөөдрийн тэтгэврийн шимтгэл буюу 17 хувийн шимтгэлээс ажилтан 8,5, ажил олгогч 8,5, ингээд 2 талаасаа 17 хувийн шимтгэл төвлөрүүлж байгаа энэ асуудлаас гадна нэмэлтээр,

сайн дураар өөрсдөө тогтсон шимтгэл бас төвлөрүүлж, тэгээд хуримтлал үүсгэхийг хэлнэ.

Тэгэхээр бага цалинтай, өдөр тутамдаа илүү гаргах зардалгүй хүмүүс хувийн нэмэлт тэтгэвэр үүсгэх мөнгө байхгүй л бол энэ асуудалд хамрагдахгүй нь гэсэн үг. Тэгэхээр өндөр орлоготой, нэмэлтээр ийм сан үүсгэх боломжтой, дээрээс нь мэдээж нөгөө ажил олгогчийн илүү ээлтэй зохицуулалтуудыг оруулж ирж байгаа ийм хувилбараар энэ хуулийн төсөл бол маш зөв. Энийгээ аваад явах нь зүйтэй.

1 тодруулах гээд байгаа юм нь болохоор зөвхөн аж ахуйн нэгж, байгууллага, компани хоорондоо, ажилтан хоорондоо үүсгэх гээд байгаа сан байна уу. Эсвэл одоогоор үүсчихсэн байгаа сангууд буюу Нэшнл лайф байна, Ард байна. Бусад энэ сангуудад хамрагдах боломжийг нь нээлттэйгээр адилхан үлдээх гэж байна уу. Энэ зөрөө нь байна уу, үгүй юу гэдгийг ажлын хэсгээс ямар нэг өөрчлөлт гарсан уу, үгүй юу гэдгийг тодруулж асууя.

Ер нь бол одоо нийгмийн даатгалын багц шинэчлэл реформыг, бидний анх санаа бас хийж чадаагүй энэ реформыг Аубакир сайд хийхээр Засгийн газар ажиллаж байгаа нь маш сайн хэрэг. Тэгээд бидний зүгээс юу гэдэг юм, өргөн бариагүй байхад ямар ч мэдээлэл гадагшаа гаргахгүй нь бол зүйтэй. Энэ дээрээ зүгээр би тодруулж бас юуг хэлэх гээд байна вэ гэхээр үнэхээрийн нэмэлт тэтгэврийн эх үүсвэрийг ахмадууддаа нийтлэгээр өгөх гэж байгаа бол 1 дүгээрт суурь тэтгэвэр гэдэг маш чухал. Улсын Их Хурлын гишүүд өнөөдөр төсвөөс хэрхэн яаж тэтгэврийг нэмэгдүүлэх вэ гэж ярих гэж байгаа бол суурь тэтгэвэр гэдэг ойлголтыг оруулж ирээд, тэр жилийнхээ төсөвтөө багтаагаад энэ суурь тэтгэврээ хэдээр нэмэх вэ гэдгийгээ тогтоодог байх нь зүйтэй.

2 дахь давхарга нь мэдээж НДШ хэр сайн төлж, ямар цалингаас шимтгэл төлсөн юм, хэдий хугацаанд төлсөн юм гэдгээсээ яваад, 3 дахь нь магадгүй энэ хувийн тэтгэврээсээ гадна баялгийн сангаасаа тэтгэвэр авдаг баймаар байна. Яагаад гэвэл .../минут дуусав/

П.Ганзориг: Нэмэлт минут өгье.

А.Ариунзаяа: Яагаад гэвэл яг баялгийн сандаа бид нар Норвег болон Сингапурын баялгийн сангийн жишээг аваад, хуримтлал үүсгээд, хүн бүрийн нэрийн дансан дээр нь тодорхой мөнгө байгаад, тэгээд үүнийгээ эрүүл мэнд, боловсрол, орон сууцанд зарцуулна гэсэн ийм хууль хэрэгжиж байгаа. Гэтэл эрүүл, боловсрол эзэмшээд дүүрчихсэн. Тэгээд орон сууцын хэрэгцээгээ хангачихсан хүмүүс тэгвэл энэ байгалийн баялгаасаа иргэн бүрд хүртээж байгаа тэр баялгийн сангийн нэрийн дансанд байгаа мөнгөө яаж авах вэ гэхээр бусад улс орон тэтгэврээр л дамжуулж өгдөг байхгүй юу. Тэгэхээр энэ боломжийг бас одоо энэ хуулиараа нээж өгөх хэрэгтэй. Хэн нэгэн хаа нэгтэйгээс илүү мөнгө авах гээд байгаа юм биш. Угаасаа хүн бүрийн нэрийн данс дээр нь байгаа тэр асуудлыг юунд зарцуулах вэ гэдэг л эрхийн тухай асуудал байгаа учраас баялгийн сан дээр яг энэ тэтгэвэрт гэдгийг нь бас оруулах хэрэгтэй. Бид нар чинь Сингапураас зөндөө л танилцах айлчлалын .../минут дуусав/

П.Ганзориг: Аубакир сайд хариулъя.

Т.Аубакир: Энэ яах арга байхгүй бас олон жил хүлээгдэж байсан ийм харилцаа л даа. Яг өнөөдрийн байдлаар манай улсын хэмжээнд 135 мянга орчим

иргэн 80 гаруй тэрбум төгрөг төвлөрүүлчхээд явж байгаа. Энэ маань 4-5 том аж ахуйн нэгжүүд байна. Өөрсдийнхөө ажилтнууд дээр хувийн нэмэлт маягаар ингээд тэтгэврийн сан бүрдүүлчихсэн. 80 орчим тэрбум төгрөг.

Гэхдээ яг энэ харилцааг зохицуулж байгаа хууль, эрх зүйн орчин 1 дүгээрт байхгүй байгаа. 2 дугаарт бас хэдий цөөн ч гэсэн зарим хүмүүс маань 2 дахь эх үүсвэрээс тэтгэвэр авдаг болохыг хүсэж байгаа эрэлт бас байгаад байна. Тийм учраас эдгээр харилцааг зохицуулж өгөх, нөгөө талдаа мэдээжийн хэрэг олон улсын хэмжээнд сайн туршлагауд байна. Иргэдийн хуримтлуулсан энэ сангийн мөнгөөр бусад салбарууддаа хөрөнгө оруулалт хийдэг. Жишээлбэл, зарим гаднын улсууд бараг ДНБ-тэй 100 хувь тэнцэхүйц хэмжээний хүртэл сан босгочихсон. Түүгээрээ бусад салбарууддаа хөрөнгө оруулалт хийгээд явдаг ийм сайн жишээнүүд байгаа юм.

Өнөөдрийн байдлаар манайд 80 орчим тэрбум төгрөг 135 мянга орчим иргэний хуримтлал бий болчихсон байна. Эрх зүйн орчин нь байхгүй байна. Эрх зүйн орчныг нь бий болгоё. Нөгөө талдаа бас нэг сайн зүйл нь Ариунзаяа гишүүнтэй би санал нэг байна. Өндөр цалинтай хүмүүст дахиад 2 дахь эх үүсвэр бий болчихно. Хамгийн гол зүйл бол манай улсад дахиад шинэ хөрөнгө оруулалтын эх үүсвэр бий болчихно. Тийм учраас энэ хуулиа санаачлаад, Байнгын хороогоор хэлэлцүүлж байна. Улсын Их Хурлаар хэлэлцүүлээд бас ингээд батлаад гарах зайлшгүй нийгэм, эдийн засгийн шаардлага үүсчихжээ гэж үзэж байгаа юм.

Тэгээд тэтгэврийн даатгалын шинэчлэлийн хүрээнд олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлнэ гэж олон жил бид зорилт тавьж байгаа. Үүний маань нэг хэлбэр энэ. Нийгмийн даатгалын багц хуулийн ерөнхий шинэчлэл бол явж байгаа. Яг одоо эцэслэгдээгүй. Төсвийн үр дагавар ихтэй учраас бид нар бас эрт ингээд энэ зүйлүүдээ яриад, нийгэмд хүлээлт үүсгээд явах, нөгөө талдаа мэдээжийн хэрэг иргэдийн авч байгаа тэтгэвэр маань амьжиргааны доод түвшинтэй зайлшгүй уялдах ёстой, хөдөлмөрийн хөлсний доод түвшинтэй зайлшгүй уялдах ёстой. Одоо насжилт өндөр болж байна шүү дээ. Энэ маань зөвхөн манай Монгол Улсын проблем биш. Дэлхийн проблем болчихож. Насжилт өндөр байгаад байдаг. Тэр хэмжээгээрээ дэлхийн улс орнуудын нийгмийн даатгалын санд ирж байгаа ачаалал их байгаа учраас бид нар угтуулаад удахгүй ирэх 7 хоногуудаас бид нар Засгийн газраар хэлэлцүүлээд, Нийгмийн даатгалынхаа багц хуулийг бас оруулж ирнэ. Яг энэ дээр би санал нэг байна. Саяын суурь тэтгэврийн асуудлыг бид нар нэвтрүүлэх зайлшгүй шаардлагатай. Нөгөө талдаа бид нар төсөвт ирж байгаа ачааллыг эх үүсвэрийг нь хаанаас харах вэ гэж. Баялгийн сангийн тухай хуулийн асуудал бас гишүүдээс санал гарч байгаа. Тийм учраас сүүлд Ариунзаяа гишүүний асуусан асуулт дээр манай ажлын хэсгээс бас нэмээд хариулаарай.

П.Ганзориг: Ажлын хэсгээс хэн хариулах вэ. Санхүүгийн зохицуулах хорооноос төлөөлөн хариулах юм уу. Индрийн микрофоныг нээе.

Б.Батжаргал: Ариунзаяа гишүүний асуултад хариулъя. Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Батжаргал. Хуулийн төсөл дээр бол 2 төрлийн хөтөлбөрөөр энэ даатгалд хамрагдах боломжийг нээж өгсөн.

1 дүгээрт ажил олгогчийн хөтөлбөр,

2 дугаарт хувь хүний хөтөлбөр.

Ажил олгогчийн хөтөлбөр гэдэг бол тухайн 1 байгууллагатай гэрээтэй, тэгээд яг хөдөлмөрийн гэрээгээр ч юм уу ажиллаж байгаа албан журмын ажилтнуудыг бол даатгуулж болно гэж оруулж байгаа.

Хувь хүний хөтөлбөр бол тухайлсан 1 ажилтан албан албан байгууллагад ажилладаггүй, хувиараа бизнес эрхэлдэг хүмүүс даатгуулж болно гэсэн ийм зохицуулалтуудыг оруулж өгсөн байгаа. Одоо зах зээл дээр ажиллаж байгаа зарим байгууллагуудын хувьд бол зарим нь бол Төрийн бус байгууллагын тухай хуулиар, зарим нь Компанийн тухай хуулиар, зарим бол Даатгалын тухай хуулиар ч юм уу ингээд зохицуулагдаад яваад байгаа. Тэгэхээр хуулийн төслийн 47 дугаар зүйл дээр шилжилтийн зохицуулалт гээд оруулж өгсөн байгаа. Тэгээд энэ 1 жилийн хугацаанд шилжилтээ хийж, энэ хуультай нийцүүлж үйл ажиллагаагаа нийцүүлнэ гэсэн ийм зохицуулалтыг бас оруулчихсан байгаа. Баярлалаа.

П.Ганзориг: Ариунзаяа гишүүн тодруулъя. ажилтан.

А.Ариунзаяа: Одоо ажилтан НДШ төлөх дээд хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 8 дахин нэмэгдүүлсэн байгаа билүү, 10 билүү. 10 байгаа. Сайн дураар бол 7 байгаа юу. Ажил олгогч болохоор хязгааргүй байгаад байгаа. Тэгэхээр Түвшин нарын өргөн барьсан байгаа хуулийг уг нь зэрэгцүүлээд хэлэлцээд явмаар байгаа юм. Ажил олгогчийн энэ хэмжээ хязгаарыг бас тавьж өгөхгүй бол тэрнээсээ давсан хэсэг дээрээ л уг нь сайн дураараа төлөх сэдэл үүснэ шүү дээ. Мөн түүнчлэн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулсан байгаа нь миний бодлоор их буруу санагддаг юм. Тэгээд сайн дур болон албан хөдөлмөр эрхэлж байгааг хооронд нь нийцүүлэх буюу 10 дахин нэмэгдүүлсэн чинь улам л нэмэгдээд маш их өндөр болчихоод байна. Аль ч талаараа бодсон үнийг бууруулах хэрэгтэй. Энийг шинэ хууль .../минут дуусав/

П.Ганзориг: Ажлын хэсгээс хариулах уу. Индрийн микрофоноос хариулъя.

Б.Батжаргал: Ариунзаяа гишүүний асуултад хариулъя. Нийгмийн даатгалын ерөнхий газар Батжаргал. Ажил олгогчийн төлж байгаа дээд хязгаар тавих асуудал бол энэ хуулийн төсөл болон дагаж өргөн мэдүүлсэн хуулийн төсөл дээр бол байхгүй. Нийгмийн даатгалын багц хуулийн нэмэлт, өөрчлөлт дээр тэр агуулгыг бол тусгаад, бид нар тооцоогоо хийгээд бэлдчихсэн байгаа. 10 дахин. Тэгэхдээ энийг бас үе шаттай хийхээр бид нар тооцоогоо бас оруулчихсан байж байгаа. Энэ хуулийг дагаж өргөн мэдүүлсэн хууль дээр бас байж байгаа. Агуулга нь.

П.Ганзориг: Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн асуулт асууя.

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээр энэ хуулийн төсөл бол хувийн нэмэлт тэтгэврийн тухай энэ хуулийн төслийг бол маш чухал гэж харж байгаа. Зарчмын хувьд дэмжиж байна. Энэ ер нь бол хүн амын насжилтыг харах юм бол 2050 он гэхэд 5 хүн тутмын 1 нь тэтгэврийн насны хүн болж нэмэгдэхээр байгаа. Одоо бол 10 хувь байгаа шүү дээ. Тэгэхээр бид бас өнөөдөр байж байгаа энэ нийгмийн даатгалын сангийн өнөөгийн нөхцөл байдлыг харахад энэ тэтгэврийн даатгалын сан нь бол 590,1 тэрбум төгрөгийг жилдээ төвлөрүүлээд, тэгэхдээ 877 тэрбум төгрөгийг зарцуулаад байгаа юм. Тэгэхээр 312 тэрбум төгрөгийн ийм алдагдалтай жил болгон яваад байгаа. Тэгэхээр энэ тохиолдолд бид бас энэ хувийн тэтгэврийн санг safety net буюу өнөөдрийн тэтгэврийн гол бүрдүүлж байгаа дээр нэмэх байдлаар оруулж ирж байгаа нь бол туйлын зүйтэй гэж харж байна.

Хэдэн жилийн өмнө орж ирэхдээ л энэ 5 багц хуулийнхаа 1 нь болж орж ирсэн бол бид бас арай илүү түвшинд оччихсон байсан байх болов уу гэж бодоод байгаа юм. Бид бол энэ дээр хэд хэдэн зүйлийг бас бодох ёстой гэж харж байна.

1 дүгээрт энэ дэлхий нийт чинь ер нь хөрөнгө оруулалтын бараг 46 хувь нь зөвхөн тэтгэврийн сангаасаа бүрдэж байна гэж ярьж байна. Банкнаас хөрөнгө оруулалтаа татаж ирсэн энэ 30 жил бол алдаатай байсныг харуулаад байна шүү дээ. Дандаа богино хугацаанд, үсрээд 3 жилийн 36 сарын л хүүгийн юу яаж байгаа шүү дээ. Гэтэл мега том төслүүд бол 10 жилээр яригддаг. Тэгэхээр ийм төслүүд рүү бол ийм тэтгэврийн сан орж ирж байж энэ төслүүд бол урагшилна гэдэг нь ойлгомжтой. Эдийн засгийн маш том эргэлт орж ирж байна гэдэг нь бол эндээс харагдаж байгаа юм.

Тэгэхээр энэ дээр жишээлбэл ХҮН нам бас өөрсдийнхөө мөрийн хөтөлбөр дээрээ тавьсан байгаа. Өнөөдөр 17 хувьтай байгаа. Өөрөөр хэлбэл 8,5-ыг нь ажил олгогч, 8,5-ыг нь өөрөө төлөөд, ингээд тэтгэврийн санг бүрдүүлээд явж байгаа. Үүнийг бол үе шаттайгаар 10 хүртэл хувийг нь яг энэ хөрөнгө оруулалт руу, өөрөөр хэлбэл ашиглаж болдог НДШ төлөгч өөрөө аль сангаар дамжуулж ямар юугаа хийхээ өөрөө мэддэг ийм тогтолцоо руу оруулах нь зүйтэй гэж хараад байгаа юм. Тэгэхгүй бол өнөөдрийн санхүүгийн нөхцөл байдал чинь их хэцүү шүү дээ. Яг өндөр цалинтай ийм байдлаар ингээд шууд өөрөө хувийн тэтгэврийн санд нэмэлтээр ингэж хураамжаа өгөх, шимтгэлээ төлөөд явах ийм хүн бол ховор байгаа. Өнөөдрийн өдөр тутмын энэ цалингаа төлж байгаа энэ хүмүүстэй ингээд харьцуулахад. Тэгэхээр энэ дээр 2, 3 зүйл асуух гэсэн юм.

1 дүгээрт та бүхэн өнөөдөр байж байгаа 17 хувийг үе шаттайгаар нийгмийн даатгалын ерөнхий сангаасаа элдэв тэтгэврийн сангууд руу мэдээж хууль дээр эрсдэлийг нь зөв тооцоод, ийшийгээ хөрөнгө оруулах ийм боломжуудыг нь шимтгэл төлөгчид олгох уу. Ийм заалт энэ хуулийн төсөлд байгаа юу гэдгийг 1 дүгээрт асууя.

Миний тодруулгыг өгчхөөрэй.../минут дуусав/

П.Ганзориг: Нэмэлт минут өгье.

П.Наранбаяр: 2 дугаарт болохоороо зэрэг баталгаат өгөөжийн асуудал энэ хуулийн төсөлд ер нь ямар байдлаар туссан бэ.

3 дугаарт нь бол энэ хөрөнгийн менежментийн компаниудаар дандаа дамжуулж, жишээлбэл хамгийн найдвартай санхүүгийн хэрэгсэл гэх юм бол Засгийн газрын бонд, төв банкнаас гаргасан бондууд ч юм уу, нийслэлийн бонд ч гэдэг юм уу ардаа төсөвтэй явдаг ийм бондууд байдаг. Энийг худалдан авах нөхцөлд бол хөрөнгө оруулалтын менежментийн компаниудаар зайлшгүй дамжуулах шаардлагагүй гэж үздэг. Тэд нар чинь ингээд зөвхөн дамжуулсныхаа хөлсөнд бол 2 хувийг нь шимтгэл болгоод авчаж байгаа шүү дээ. Ийм зүйлийг хэр зэрэг чөлөөтэй болгосон бэ. Шууд харилцах ийм боломжийг бий болгосон уу гэсэн ийм асуулт байна. Ингэж бид энэ хөрөнгийн менежментийг зөвөөр хийх юм бол Монгол Улс санхүүгийн маш том өөрийн гэсэн хөрөнгө оруулалтын зах зээлтэй болох нь.

2 дугаарт бас өнөөдөр байж байгаа энэ бичилтүүд яг зөвхөн хийсвэр биш бодитой тоо бол .../минут дуусав/

П.Ганзориг: Аубакир сайд хариулъя.

Т.Аубакир: Наранбаяр гишүүний асуултад хариулъя. Бид нар менежмент хийх компанийг заавал тусгаж өгч байгаа юм. Яагаад гэхээр бас яг өнөөдрийн энэ нийгмийн сэтгэл зүй яг энэ асуудалд бас бэлэн байна уу. Бид нарт өмнө нь бас улсын хэмжээнд тохиолдож байсан асуудлууд бий. Энэ санд хуримтлуулж байгаа, төлж байгаа шимтгэл бол энэ өөрөө нийтийн эрх ашгийн асуудал бас байгаад байгаа юм. Тэгээд маш олон хүний асуудал. Энэ дээр бид нар ХХК байх ёстой. Мөн 1 хувьцаа эзэмшигчийн хувь нь 20 хувиас хэтрэхгүй байх ёстой гэсэн хамгаалалтуудаа эхний ээлжид хийж өгөхгүй бол нийтийн эрх ашиг гэдэг ойлголт байдаг. Та өөрөө сайн мэдэж байгаа.

Сая бас өнгөрсөн хугацаанд манай дээр энэ эрх зүйн зохицуулалтгүй байсан нийтийн эрх ашгийг хамгаалах жишээлбэл койны асуудал байна. Ямар ч зохицуулалтгүй байж байгаад, маш олон хүн хохироод, ингээд чимээгүй л өнгөрсөн. Тийм учраас бид нар эхний ээлжид менежментээ ийм ийм тусгай зөвшөөрөлтэй компаниудаар хийлгэнэ гэдэг заалтыг энд тусгаж өгсөн байгаа. Тусгай зөвшөөрлийг бид нар энэ кастодионы үйлчилгээг заавал авах ёстой гэж бас оруулж ирж байгаа юм. Хууль дээрээ зааж өгсөн. Энэ маань яах вэ яг үндсэн Нийгмийн даатгалын сандаа бид нар бас хүндрэл учруулахгүй явах ёстой. Яг өнөөдөр бас Нийгмийн даатгалын сан дээр ямар ямар төрлийн сегментүүдэд хөнгөлөлт эдлүүлснээс болоод Нийгмийн даатгалын сангийн маань орлого, зарлагын харьцаа бас холдсон. Тийм учраас бид нар энэ хуулиараа үндсэндээ нэмэлтээр сонголтоор үйлчлүүлэх, нөгөө талдаа яг нийгмийн даатгалынхаа үндсэн санг бид нар цэвэр шимтгэл дээрээ суурилсан яг сонгодог утгаараа энэ Нийгмийн даатгалын сан гэдгээр нь аваад явах юм бол айхтар тийм ирээдүй бас харагдахгүй байгаа. Нэг их тийм айхтар муудчихсан сан бас биш. Нөгөө талдаа хамгийн гол нь улс төр орсон улс төрчдийн маань иргэн Аубакирын НДШ-ийг хөнгөлчихье. Ингээд 50 хувийг нь ингэчихье, эсвэл огт төлүүлэхгүй байя гэсэн зүйлүүдээс болоод мэдээжийн хэрэг Нийгмийн даатгалын санд бас хүндрэлүүд учирч байгаа зүйлүүд бий.

Нөгөө талдаа иргэдийн насжилттай холбоотой зөвхөн манай улсын асуудал биш болсон байна. Дэлхий даяар насжилт уртсаж байгаатай холбоотой бид нар эргээд тэтгэвэрт гарсан ч гэсэн эргээд хөдөлмөр эрхлэх ямар бололцоонууд байна, цаашдаа цаашдаа олон жил нийгэм даатгалын шимтгэл төлүүлэхийн тулд яах ёстой юм гэсэн хөшүүргүүдээ бид нар нөгөө багц хуулийнхаа, Нийгмийн даатгалын хуулийн нэмэлт, өөрчлөлтүүдээр бас оруулж ирж байгаа Наранбаяр гишүүн ээ. Энэ дээр яг цэвэр бид нар Монгол Улсад хөрөнгө оруулалтын шинэ эх үүсвэр бий болгох юм. Одоо 80 орчим тэрбум төгрөг төвлөрсөн байна. Яг таны хэлж байгаа зөв. Дэлхийн улс орнууд маань энэ тэтгэврийн санг хамгийн том хөрөнгө оруулалтын сан болгож чадсан байна шүү дээ. Тийм учраас бид нар өнөөдөр энэ хууль маань анх орж ирж байгаа. Магадгүй 5, 10 жилийн дараа сайн эффектүүдээ үзүүлээд явуулах байх гэж харж байгаа.

П.Ганзориг: Ажлын хэсгээс индэр дээрээс нэмээд хариулчихъя.

Б.Батжаргал: Наранбаяр гишүүний асуултад хариулъя. Нийгмийн даатгалын ерөнхий газар Батжаргал. Хуулийн төслийн 5.1.14 дээр баталгаат өгөөжийг тусгасан байгаа. Нэр томъёоных нь хувьд баталгаат өгөөжтэй байхаар тусгана. Энийг өгөөжийн асуудлыг гэрээнд заавал тусгаж, хэрэгжүүлж явна гэсэн заалтыг нь хуулийн төсөлд тусгасан байж байгаа. Тоогоор бол илэрхийлээгүй.

П.Ганзориг: Индрийн микрофоныг нээе. Ажлын хэсгийнхэн яг энэ тоотой холбоотой нарийн асууж байгаа зүйл, заалтыг нь тэмдэглэж авч байгаад, гишүүдийн асуултад яг бүрэн гүйцэд хариулаарай.

Б.Батжаргал: 2023 онд баталсан нийгмийн даатгалын багц хуулийн заалт дээр одоо мөрдөгдөж байгаа 1заалт нь 17 хувиас ажил олгогчийн 1 хувь, даатгуулагчийн 1 хувийг тэтгэврийн нөөц санд бүрдүүлэх хуулийн заалт одоо бас мөрдөгдөж байгаа. Гэхдээ бас харамсалтай нь тэтгэврийн сангийн орлогын бүрдүүлэлт болон зардлын өсөлтөөс хамааруулаад бид нар хангалттай хэмжээний бас бүрдүүлж чадахгүй байгаа. Тэгэхээр энэ дээр манай барьж байгаа бодлого яамны хувьд бол одоогийн нэмэлт, өөрчлөлтөөр 17 хувиас 1 хувийг нь даатгуулагчийн төлж байгаа 1 хувийг өөрөө хүсвэл яг хагас хуримтлалын зарчим руу оруулаад явах ийм шинэ концепцыг бас ингээд оруулж байгаа. Тэгэхээр одоогийн энэ өргөн барьсан хуулийн төсөл бол одоогийн мөрдөж байгаа 17 хувиас ямар нэгэн шимтгэл хуваалцахгүй гэсэн зарчмаар хуулийн төсөл бичигдсэн байгаа.

П.Ганзориг: Наранбаяр гишүүн тодруулъя.

П.Наранбаяр: Тэгэхээр өнөөдөр ахмадууд бол гадаа жагсаад, тэтгэврийн жагсаал болоод, өнөөдөр Монгол хүн тэтгэвэртээ гараад л маргаашаас нь ядуурдаг ийм тогтолцооноос бид салахын тулд энд сууж байгаа гэж ойлгож байгаа. Ингээд харах юм бол бид бас 1 хувь гээд ингээд өнөөдөр 17 хувиасаа өөрөө сонгоод энэ ашигтай ажиллаад байгаа ийм сан руу хөрөнгийн менежментийн компаниар дамжуулсан ч болно. Би тэдэн хувиа өгье гэдэг ийм боломжийг нь энэ хууль бас олгоогүй юм байна гэж харж байна. Тэр шимтгэлийг хуваалцах юмыг оруулаагүй гэсэн ийм юм ярьж байна. Тэгэхээрээ ингэж болохгүй л дээ. Энэ үе шаттайгаар энэ чинь явж байгаад яах вэ 7 хувь бол safety net буюу амьдралын баталгаат тэр орчин тэрийгээ хангана. Түүнээс дээших 10 хувь дотроо бол яг энэ тэтгэврийн шимтгэл төлөгч өөрөө энийгээ сонгоод ингээд явах боломжийг нь олгох ёстой гэж харж байна. Ер нь бол бид ахмад хүмүүс нэмэгдээд, тэтгэврийн насныхан нэмэгдэх тусам хөрөнгө оруулалт нэмэгдэх ийм боломж байна гэж бас харах ёстой шүү. Ингэж л бид харж байж энэ чинь өөрөө нийгэмдээ зөвөөр үйлчилнэ гэж харж байгаа. Энэ дээр .../минут дуусав/

П.Ганзориг: Ажлын хэсгээс хариулах уу. Аубакир сайд хариулъя.

Т.Аубакир: Наранбаяр гишүүний хэлж байгаа санаа бол зөв. Одоо яг өнөөдөр Монгол Улсын хэмжээнд 1 сая 300 орчим мянган иргэн хөдөлмөр эрхлээд, НДШ төлж байгаа. Нөгөө талдаа 520 гаруй мянган иргэн тэтгэвэр аваад явж байгаа. Түүрүүн таны хэлсэн яг 2030 он гэхэд үндсэндээ 1 НДШ төлөгч маань 1 тэтгэвэр авагчийг даах хэмжээнд очих гэж байна шүү дээ. Хүн ам зүйн бодлого маань энэ. Энэ маань нөгөө талдаа бид нар дахиад энэ ахмадуудыгаа тэтгэвэрт гарчихсан уу, тэгвэл амар гэх биш, эргээд дахиад хөдөлмөр эрхлэх ямар бололцоо байна. Насны асуудал ч яригддаг. Ний нуугүй хэлэхэд. 55, 60 гэдэг бол бас жирийн шахуу нас болчихлоо шүү дээ. Тийм учраас энэ дээр бид нар дараа дараагийн хуулиудаар эдгээр асуудлуудыг оруулж ирж байгаа. Энэ маань анхдагч хууль учраас бид нар нөгөө талдаа энийг бол хөрөнгө оруулалтын шинэ эх үүсвэр, нөгөө талдаа иргэн тэтгэвэр авагчийн 2 дахь эх үүсвэрээс бас тэтгэвэр авах бололцоог нь бүрдүүлж өгч байгаа гэдэг талаас нь харж хийсэн хууль.

П.Ганзориг: Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн асуулт асууя.

М.Нарантуяа-Нара: Өдрийн мэнд хүргэе. Тэгэхээр Монгол Улс олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд шилжих, иргэд зөвхөн улсын халамжаас хамааралтай биш, хувийн хуримтлалтай болох эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлага бол аль эрт үүссэн байсан. Хэрэгцээ шаардлага. Тийм учраас энэ хуулийн төслийг бол зарчмын хувьд дэмжиж байгаа. Гэхдээ дэмжихийн зэрэгцээ үүсэж болзошгүй байгаа эрсдэлүүдийн талаар бол шат шатад бас ярилцаж, хэлэлцэх нь зүйтэй гэсэн ийм бодолтой байна. Тэгээд ингэж байгаа юм. Дундаж орлоготой иргэдийн хувьд өрхийн орлого цалингаа зөв зохистой зарцуулснаар хувийн нэмэлт тэтгэврийн санд хуримтлал үүсгэх боломжтой гэж заасан байгаа. Гэтэл яг үнэндээ дундаж цалин авч байгаа иргэдийн дийлэнх нь цалингийн болон ипотекийн зээл, тэгээд дээрээс нь инфляцын дарамтаас үүдэлтэй үнийн өсөлт, хэрэглээний зардал нь өдөр болгон л өндөр үнэтэй болж байгаа ийм нөхцөл байдалтай байхад ер нь иргэдэд цалингаа зохицуулбал хуримтлалтай болно гэж хэлэх амархан ч гэсэн яг үнэндээ бодит байдал дээр амьдрал дээр илүүчлээд, нэмэлт тэтгэврийн санд хамрагдах боломж нь хэр байгаа юм бол. Энэ талаар нарийвчилсан судалгаа байна уу.

2 дугаарт энэ хууль батлагдсанаар ер нь өндөр орлоготой иргэд хувийн тэтгэврийн сангаар дамжуулаад ирээдүйд улам баялаг их хуримтлалтай болох, өндөр тэтгэвэр авах нь тодорхой болчхож байгаа юм. Харин дундаж болон түүнээс доогуур орлоготой иргэдэд өнөөдрийн амьжиргаагаа арайхийж залгуулж байгаа хүмүүст бол энд хамрагдах боломж ер нь хомс байна шүү дээ. Тэгэхээр энэ өөрөө ялгаатай байдал нь ирээдүйд тэтгэврийн тэгш бус байдал, баян хоосны ялгааг үүсгэх энэ байдлыг улам гүнзгийрүүлчих юм биш байгаа. Үүнээс сэргийлээд дундаж орлоготой иргэдийг нийтээр нь хамруулах төр, хувийн хэвшлийн ямар түншлэлийн механизмыг энэ хуульд хэрэгжүүлэхээр тусгасан бэ. Өөрөөр хэлбэл ирээдүйд үүсэж болзошгүй байгаа тэгш бус байдлыг л даамжруулахгүй байх эрсдэлээс хэрхэн яаж хамгаалах вэ.

3 дугаарт энэ хуулийн үйлчлэлд хамаарч ирээдүйдээ бодит хөрөнгө оруулах зорилтот бүлэг нь яг хэн юм Өндөр орлоготой иргэд юм уу, эсвэл дундаж орлоготой болон хоёуланд нь юм уу гэдэг ийм асуулт байгаа. Тэгээд энэ хууль хэрэгжээд эхлэх юм бол өндөр орлоготой хэсэгт л илүү ашигтай, тэгээд тэд нарын татвараас зайлсхийх эсвэл татвараа бууруулах хэрэгсэл болох бас магадлалтай байж болзошгүй харагдаж байгаа байхгүй юу. Тэгээд хамгийн гол нь жишээлбэл дундаж орлоготой хүн сарынхаа хэрэглээнээс танасаар байгаад, танасаар байгаад сардаа 50, 100-г илүүчлээд, тэтгэврийн нэмэлт санд ингээд хуримтлуулаа гэж бодъё. Гэтэл нөгөө хамаг хэрэглээгээ танаж байгаад орсон энэ юу чинь ирээдүйд энэ инфляцын түвшнийг дундаж түвшнийг нь тооцох юм бол 20 жил .../минут дуусав/

П.Ганзориг: Нэмэлт минут өгье.

М.Нарантуяа-Нара: 20 жилийн дараа тэр иргэний цуглуулсан мөнгө үнэгүйдэхгүй байх баталгаа юу байна гэдэг тал дээр. Тэгээд эхлээд энэ асуултдаа хариулт авчихъя.

П.Ганзориг: Аубакир сайд хариулъя.

Т.Аубакир: Бид нар зах зээл дээр яг нэмэлт тэтгэврийн буюу хувийн нэмэлт тэтгэвэртэй болох эрэлт хэрэгцээ байна гэж үзэж байгаа юм. Яагаад гэхээр яг өнөөдрийн байдлаар 135 мянган иргэн маань сонгоод даатгуулчихсан байна шүү дээ. 80 орчим тэрбум төгрөг, 4-5 аж ахуйн нэгж дээр төвлөрчихсөн байгаа. Энэ

маань цаашдаа бас яг эрх зүйн орчин нь тодорхой болоод ирэх юм бол өшөө ч хуримтлуулах зах зээл тодорхой хэмжээнд байна гэж харж байгаа.

Нөгөө талдаа яг өнөөдрийн авч байгаа тэтгэврийн хэмжээ, амьжиргааны доод түвшин, энэ өргөн хэрэглээний барааны үнийн өсөлт зэрэг маш олон зүйлүүдтэй уялдаж явдаг. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ. Худалдан авах чадварыг нь бууруулахгүйн тулд бид нар бас Засгийн газар дээр ярьж байгаа. Тэтгэвэр, цалингаа бид нар нөгөө өргөн хэрэглээний барааны үнийн өсөлттэйгөө уралдаад нэмээд байж болохгүй. Нөгөө талдаа Засгийн газар маань өргөн хэрэглээний барааны үнийг барьдаг механизмаа заавал ажиллуулах ёстой. Уралдаад л нэмээд л байдаг, 10 жилийн дараа эргээд харсан чинь нөгөө Монгол төгрөгийн ханш маань юу болж хувирах вэ тийм ээ. Тийм учраас бид нар Засгийн газар дээр саяын 1 тод жишээ бол махны үнийн өсөлт байлаа шүү дээ. Яагаад гэхээр яг хамгийн түрүүнд үнийн өсөлтөд нэрвэгддэг хүмүүс маань ерөөсөө тэтгэврийнх. Яг ид хөдөлмөрийн насны залуучууд маань юу гэдэг юм өдөртөө гүйж гараад л 100, 150 мянган төгрөгийн ажил хийчих бололцоо байгаад байдаг. Яг ахмадууд маань үнийн өсөлтөд цэвэр нэрвэгдэж байгаа байхгүй юу. Тийм учраас бид нар наад зах нь 5 нэр төрлийн мах, гурил, элсэн чихэр, цагаан будаа гэдэг юм уу, эд нарынхаа үнийг барьдаг, үнэ хэт өсөөд ирэхэд нь интервенц хийх чадвар энэ төрд заавал байх ёстой. Тэгж байж бид нар энэ үнийн өсөлт, саяын энэ тэтгэвэр авч байгаа хүмүүсийн мөнгөний ханшийг, үнэ цэнийг унагаахгүй байх, ядууралд нэрвэгдүүлэхгүй байх. Бид нар дараагийн яг энэ даатгалын хуулийнхаа нэмэлт, өөрчлөлтөөр оруулж ирэхэд нэлээн чухал чухал өөрчлөлтүүдийг оруулж ирж байгаа. Ерөөсөө яг авч байгаа тэтгэвэр маань тухайн үнийг амьжиргааны доод түвшинд яаж оруулахгүй байх ёстой юм бэ гэдэг гол механизмуудаа бид нар тэр хууль дээр хийж өгч байгаа. Энэ хуулийн маань гол концепц маань саяын 130 гаруй мянга, энэ цаашдаа нэмэгдэнэ. 200, 300 мянган хүн болно. Энэ одоо яг хөдөлмөрийн харилцаанд гэдэг юм уу НДШ төлөхгүй байгаа 500 орчим мянган хүн байна шүү дээ. 500 орчим мянган хүн байна. Магадгүй эдгээр дотроосоо саяын сектор, салбар луугаа хийх зэрэг бодлогуудыг уялдуулаад бид нар эхлээд хувийн нэмэлтийн хуулиа явуулж явуулж байгаад дараа нь Ерөнхий хуулийнхаа нэмэлт, өөрчлөлтүүдийг нэлээн саяын Ариунзаяа гишүүний хэлсэн суурь тэтгэврийн асуудал заавал орж ирнэ. Суурь тэтгэвэртэй байхын тулд бид нар жил хугацааг нь хүртэл тавьж өгч байгаа. Яагаад гэхээр яг өнөөдрийн тогтолцоо маань ний нуугүй хэлэхэд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр төлж төлж явж байснаа сүүлийн 5, 10 жил өндөр төлөөд л яг насаараа хөдөлмөр эрхэлсэн хүнээс илүү тэтгэвэр аваад сууж байгаа тохиолдол зөндөө шүү дээ. Тийм учраас бид нар Нийгмийн даатгалын сангийнхаа нөгөө шударга тогтолцоог барих механизмуудаа бид нар дараагийн нэмэлт, өөрчлөлтөөр оруулж ирж байгаа.

Сая 1 тоо асуугаад байсан. Манайхан нэмж хариулах хүн байна уу.

П.Ганзориг: Ажлын хэсгээс нэмж хариулах уу. Индэр дээрээс.

Б.Батжаргал: Нарантуяа-Нара гишүүний асуултад хариулъя. Нийгмийн даатгалын ерөнхий газар Батжаргал. Одоогийн яг зах зээл дээр бол яг ижил төстэй бүтээгдэхүүн үзүүлж байгаа 5 орчим байгууллага байна. Энд бол 135 мянга орчим иргэн даатгуулчихсан байгаа. Тэгэхээр энэ хүмүүсүүдийн орлогын байдлыг харах юм бол янз бүрийн орлоготой. Гол нь ажил олгогчийн хувьд ямар цалинтай байгаагаас үл хамаараад сайн ажилтнуудаа бас дэмжих зорилгоор би чамайг 5 жил нэмэлт тэтгэврийн даатгалд даатгуулъя гэсэн ийм агуулга нь бол аягүй чухал бас харагдаж байгаа.

Үнэ цэний хувьд бол сая бас сайд хариулсан. Ер нь бол баталгаат өгөөжөөрөө гол нь хамгаалах ёстой. Мөн үнэ цэнийг бол гол нь өгөөж нөхөж авах ёстой гэсэн заалтаараа хуулийн төсөл дээр баталгаат өгөөжтэй байна гэсэн заалтыг бол тусгаж өгсөн байгаа. Баярлалаа.

П.Ганзориг: Нарантуяа-Нара гишүүн тодруулъя.

М.Нарантуяа-Нара: Тэгэхээр энэ хувийн тэтгэврийн сан дампуурсан эсвэл хөрөнгө оруулалт нь эрсдэлд орж алдагдал хүлээсэн тохиолдолд иргэдийн энэ хуримтлалыг хэрхэн хамгаалах юм бол. Санхүүгийн зохицуулах хорооноос ямар нэг тэтгэврийн даатгалын сангийн баталгааны сан эсвэл нөхөн төлбөрийн систем байгуулахаар хуульд тусгасан байгаа юм уу. Эсвэл эрсдэлийг нь иргэд өөрсдөө 100 хувь даах юм болов уу. Энэ тал дээр асуулт асууя.

Тэгээд дээрээс нь энэ татвар дээр бас ямар зохицуулалт орох юм бол. Жишээлбэл, дундаж орлоготой иргэний тушаасан 1 төгрөг тутамд төрөөс татварын буцаан олголт олгох юм уу. Эсвэл ХХОАТ-аас нь чөлөөлөөд явах юм уу.

П.Ганзориг: Хорооноос тэр тооцоотой холбоотой асуултууд дээр бас тодорхой хэлчихвэл. Одоо энэ өгөөжийг нь баталгаажих доод түвшин гээд асуугаад байна шүү дээ. Тухайлбал инфляцад идэгдчихээд байна. Хуримтлал үүсгээд яваад байдаг. Маш өндөр инфляцтай, тэгээд олон жил хуримтлал үүсгэдэг, тэтгэвэрт гардаг, абсолют дүнгээрээ авах дүн маань өсчхөөд байдаг хэдий ч тухайн үеийнхээ худалдан авах чадвар төгрөг нь уначхаад байна.

2-т энэ яг дундаж давхаргад хэр нөлөөлөх юм бэ. Нөлөөлөх юм уу, үгүй юу гэж бас Нара гишүүн асуусан. Тэгэхээр эдгээр асуултуудад нь бас тодорхой та бүхэнд тоотоо хариулбал зүгээр байна. Хэдэн хувь нь хамрагдах гээд байгаа юм. Ирээдүйд 5, 10 жилийн дараа нэмэлт тэтгэврээр хэдэн хувь нь ингэж нэмэлтээр авдаг болж шилжинэ гэсэн тооцоонууд байгаа юм. Тэрийгээ бас тодорхой хэлбэл зүгээр байна.

Т.Цэрэнбадрал: Санхүүгийн зохицуулах хороо Цэрэнбадрал. Энэ хувийн тэтгэврийн нэмэлт даатгалын хуультай холбоотой Санхүүгийн зохицуулах хороо дээр хөрөнгө оруулалтын удирдлага, хөрөнгө оруулалтын сантай холбоотой асуудлууд голчлон орж ирж байгаа. Өмнө нь Аубакир сайд хэлсэн. Манай улсад 5 хувийн хэвшилд 88 тэрбум төгрөгийн хөрөнгийг цуглуулчихсан. Түүнд нь 135 мянга орчим иргэд хамрагдчихсан байгаа. Энэ дээр бол Санхүүгийн зохицуулах хорооны хувьд үзэж байгаагаар энэ хуулийн төсөлд туссанаар иргэд, ажил олгогчийн хөтөлбөрөөр дамжуулаад оролцох боломжтой байгаа. Тэгэхээр энэ дээр юу гэдэг юм заавал өндөр орлоготой биш, ажил олгогч нь компанийн ажилчдадаа даатгуулах замаар даатгалын хөтөлбөрт хамрагдаад явах бүрэн боломж байгаа гэж харж байгаа.

Зүгээр хөрөнгө удирдлагын хувьд бол Санхүүгийн зохицуулах хорооноос хөрөнгө оруулалт менежментийн компаниар удирдлагыг нь хийнэ гэж бодож байгаа. Монгол Улсад 35 орчим хөрөнгө оруулалт менежментийн компани байна. Хөрөнгө оруулалт менежментийн компанийн хувьд санхүү .../минут дуусав/

П.Ганзориг: Индэр дээр нэмэлт минут өгье. Нэмээд тодруулаад хариулчих.

Т.Цэрэнбадрал: Хууль дээр байгаа. Угаасаа хөрөнгө оруулалт менежментийн компаниар удирдана гэдгээрээ орчихсон байгаа. Тэгэхээр энэ дээр бол Санхүүгийн

зохицуулах хороо зохистой харьцааны тодорхой шаардлагууд тавьсан байгаа. Мөн даатгалын хөрөнгө оруулалтын сан дээр бас тодорхой шаардлага тавьж байгаа. Энэ хөрөнгө оруулалтын зохистой удирдлага бодлогыг Санхүүгийн зохицуулах хороогоор холбогдох журмыг нь бол хуулийн дараа бол баталж, зохицуулахаар туссан байгаа.

Баталгаат өгөөжийн хувьд тэтгэврийн хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллагын зүгээс инфляц, бодлогын хүү зэрэгтэй уялдуулан хөтөлбөртөө тусгаж орж ирнэ. Энийгээ мэдээж тэтгэвэрт хамрагдах иргэд маань өөрсдөө сонгоод, хөтөлбөрт нь хамрагдаад явах ийм боломжтой байгаа.

П.Ганзориг: Энэ хувийн нэмэлт тэтгэврийн тухай хууль бол бас Монгол Улсын нийгмийн даатгалын салбарын шинэчлэл тогтолцоо, ялангуяа энэ тэтгэврийн реформ хийхэд бас чухал нөлөөтэй 1 хэсэг эхлэл нь гэж бас гишүүд ойлгож болно. Яагаад гэхээр одоо ингээд суурь тэтгэврээр улсын яг төсвөөс татаас өгөөд асар их хэмжээний алдагдалтай сан маань явж байгаа. Тэгэхдээ яваандаа, урт хугацаанд энэ тогтолцоо маань бас олон давхаргатай болоод хувийн тэтгэврийн сангууд нь үүсээд, тэн дээрээ бас боломжтой хэсгүүд нэмэлтээр даатгуулдаг болоод, тэнд тодорхой хэмжээний сангууд бий болоод ирэхээр хөрөнгийн зах зээл дээр бас урт хугацаанд хөрөнгө оруулалт хийх боломжууд бий болоод, тэр нь өснө. Өндөр өгөөжтэйгөөр. Улсад байж байгаа тэтгэврийн сангууд бол өнгөрсөн хугацаанд бас банкуудад байж байгаад алга болсон асуудлууд байдаг. Тэгэхээр энийгээ дагаад бас улсын явж байгаа суурь тэтгэврийн санг нь ч гэсэн менежмент сайжраад явна, ил тод болоод явна. Тэгэхээр ийм байдлаар бас тодорхой хэмжээнд олон давхарга тогтолцооны нэг хэсэг нь бас эхлэл нь тавигдаад ингээд явж байгаа нь бас чухал гэж харж байгаа. Тэгээд гол нь ойрын хугацаанд энэ бусад нийгмийн даатгалынхаа нөгөө холбоотой хуулиудаа Засгийн газраас би маргаашийн хурлаар орно гэсэн ойлголт, төсөөлөл хүлээлттэй байсан. Оруулж ирээд бас тодорхой уялдаатай яриад явахгүй бол яалт ч үгүй хувийн нэмэлт тэтгэврийн асуудал яригдахаар суурь тэтгэвэр гээд бусад тэтгэврийн асуудлууд бол зайлшгүй гишүүд асууна, яригдана. Тэгэхээр энийг бас уялдуулаад явуулбал их зүгээр шүү гэдгийг бас ажлын хэсгийнхэнд хэлье.

Ингээд гишүүд асуулт асууж дууслаа. Үг хэлэх гишүүд нэрсээ өгье. Энхтуяа гишүүнээр тасаллаа. Аюушийн Ариунзаяа гишүүн үг хэлье.

А.Ариунзаяа: Энэ хуулийг одоо явуулах хэрэгтэй. Энэ чинь өмнө нь өргөн баригдаад, дараа дараагийн үе үеийн сайд нар хаширлаад, эргэж татаад явахгүй байсаар байгаад өдий олон жил боллоо шүү дээ. Үүсээгүй харилцаа юм уу гэхээр үгүй. Яг одоо бас 125 мянган хүн энэ хувийн тэтгэврийн сангуудад даатгуулаад явчихсан. Хамгийн олон хамрагдсан байгаа хувийн энэ сан гэх юм бол Ард дээр байгаа байх. Хамгийн олон хүн хамрагдсан байгаа. Тэгэхээр яах вэ, энэ хууль гарч байгаа 1 ач холбогдол нь өөрөө юу юм бэ гэхээр 1 дүгээрт энэ санд хамрагдахын ач холбогдол юу юм бэ гэдгийг нь томоор нэг талдаа сурталчилж өгч байгаа гэсэн үг.

2 дахь нь болохоор энэ чинь өгөөжтэй юм байна. Тодорхой хугацааны дараагаар миний энэ баталгаат өгөөж, энэ тэтгэврийн нэмэлт эх үүсвэр их чухал юм байна гэдгийг ойлгох тусмаа заавал чинээлэг гэлтгүй өнөөдөр санхүүгийн мэдлэгтэй хүмүүс ирээдүйдээ хөрөнгө оруулалт хийж явна л гэсэн үг. Тэгэхээр энэ хууль бол маш чухал юм гэдгийг онцлон хэлье.

Яагаад би бас бусад хуулиудтайгаа уялдуулж бас энэ сэдлийг нь төрүүлэх тийм ээ, ажил олгогч, ажилтан илүү гарсан хэсгээсээ ийм санд хамрагдах боломжийг нь хангахын үүднээс НДШ дотроо тэтгэврийн шимтгэл төлөх дээд хэмжээг та хэд маань эргэж хараасай. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэн чинь дэндүү өндөр байгаа шүү. Ялангуяа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг зах замбараагүй, тооцоололгүй хөдөлгөх тусмаа энэ зөвхөн цалин хөлсний асуудал биш, бусад маш олон шимтгэл, даатгал, бодлогуудтай уялдаатай байдаг учраа бас энэ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй 1 дүгээрт уялдуулах нь зөв юм уу, үгүй юм уу. 2 дугаарт яг энэ ажил олгогчийн төлөх хэмжээг нь хязгаарлаагүй, ажилтан талаасаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэн нь бас их өндөр байгаа шүү гэдгийг онцлон дахин дахин тэмдэглэж хэлээд байгаа юм шүү.

Засгийн газрын хурлаараа хэзээ орох юм байгаа юм. Тэр хууль дээрээ 1 дүгээрт ажил олгогчийн төлөх дээд хэмжээ хязгаарыг тогтоох, ингэхдээ 10 дахин нэмэгдүүлсэн дүн нь бол өндөр юм шүү гэдгийг бас тооцоолоорой. Тэгэхгүй бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ сая сүүлийн жилүүдийг аваад үзэх юм бол 2023 онд 550, 2024 онд 650, 2025 онд 792 мянга болсон байхгүй юу. Ингээд 3 жил дарааллаад нэмэгдүүлсэн. Энэ угтаа юу гэсэн үг юм бэ гэхээр 6 сая 500 мянган төгрөгөөр хязгаарлагдаж, би тэтгэврийн шимтгэл төлж байсан бол 7 сая 920 мянган төгрөгөөр хязгаарлагдаж, 10 сая төгрөгийн цалинтай хүн байлаа гэж бодоход үүгээрээ хязгаарлагдаж төлөх болсон гэсэн үг. Тэгэхээр энэ сар бүр тэтгэврийн шимтгэл ажилтны талаасаа сар бүр 200 мянган төгрөгийн шимтгэл илүү төлөх ийм бас санхүүгийн ачаалал үүсэж байгаа байхгүй юу.

Тэгэхээр дараагийн ээлждээ сая 2026 онд жил болгон та нар болохгүй шүү дээ гэж Энх-Амгалан сайдтай би маргаж, мэтгэлцэж, Байнгын хороо дээрээ энэ асуудлыг бас хэлэлцэж байж, хуулиараа 2 жил тутамдаа 1 юм гэж ярьж байж 2027 онд нэмэгдүүлэх үе чинь ирж байгаа. Тэгэхээр үйлдвэрчин бол 1 сая төгрөгт хүргэнэ гэж ярьдаг. Яам хэд гэж бодож байгаа юм. Ойролцоо 900 байлаа ч гэж бодоход 9 сая төгрөгөөр болж орж ирэх нь байна шүү. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэйгээ уялдуулсан бусад бодлогоо хараарай. Гадаадаас ажиллах хүч авахад хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулаагүй байх энэ болгон чинь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдсан байхад маш их санхүүгийн ачааллыг үүсгэдэг. Бизнесийн энэ эрх чөлөөг гэдэг юм уу ёстой жинхэнэ боомилж байгаа асуудал чинь үл үзэгдэгч .../минут дуусав/

П.Ганзориг: Наранбаяр гишүүн үг хэлье.

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээр энэ хуулийн төсөл бол үнэхээрийн цаг үеэ олж орж ирж байна гэж харж байгаа. Өнөөдөр тэтгэврийн шинэчлэл хийхэд бол энэ хувийн тэтгэврийн санг бий болгох, тэрийгээ хөрөнгө оруулалт руу оруулж улс орны томоохон хэмжээний мега төслүүд рүү мөн банкнаас бусад санхүүгийн ийм хэрэгсэл рүү эдгээр нь хөрөнгөө оруулж, улс орныхоо хөгжлийг авч явдаг, удаан хугацааны хөрөнгө оруулалтыг баталгаатай болгодог ийм байгаа. Өнөөдөр Оюутолгойг жишээлбэл Австралийн тэтгэвэрт гарсан хүмүүсийн л ийм сангууд бол дэмжиж байгаа шүү дээ. Ийм байдлаар явах учраас томоохон уул уурхайн төслүүд, дэд бүтцийн төслүүд энэ бүх зүйлүүд бол энэ тэтгэврийн сангийн хөрөнгө оруулалтуудаар явах ийм боломж бий болж байна гэж харж байна.

Асуудал бол байна. Жишээлэх юм бол өнөөдөр ингээд дундаж орлоготой мөн амьдралын түвшинд бас эндээ хүрч чадахгүй байгаа ч гэсэн яг НДШ-ээ тогтмол

төлөөд яваад байгаа ийм хүмүүст энэ хууль огт хамаарахгүй гэж бас хэлж бодож болмооргүй байна. Өөрөөр хэлэх юм бол энэ шимтгэлийг хуваалцах энэ зарчмыг бол энэ хууль дээр тодорхой хэмжээнд оруулж ирэх ёстой. ХҮН намын мөрийн хөтөлбөр дээр яриад байгаа шүү дээ. Бид 17 хувьтай байгааг 7 хувь хүртэл нь бол буулгаад, өөрөөр хэлэх юм бол 10 хувийг нь тэтгэврийн даатгал шимтгэл төлөгч өөрөө аль сан руу, ямар хөрөнгө оруулалт хийх юм, өөрөө шийдэх ийм боломжийг нь олгочхооч ээ л гэж ярьж байгаа юм. Тэгэхээр зэрэг өнөөдөр байж байгаа энэ нөхцөл байдал дээр бол энэ цаашаагаа ингээд явах юм бол ард иргэдийн бас амьжиргааг шууд дэмжээд явах ийм боломжтой гэж ингэж харж байгаагаа илэрхийлье.

Ийм учраас хуулийн төсөл дээр тэр шимтгэл хуваалцах зарчмыг бас тодорхой хэмжээнд оруулж ирж, тэгэхдээ 1 дор шууд 10 хувь гэхгүй байгаа шүү дээ. Бид бол энийгээ үе шаттай явах ёстой гэсэн ийм байр суурьтай байгаа гэдгийг 1 дүгээрт хэлье.

Мөн бас нэг асуудал бол энэ баталгаат өгөөжийн асуудал. Энэ бол өнөөдрийн хууль дээрээ бас хамгийн боломжтой хувилбараараа ороод ирчихсэн байна гэж харж байна.

Эцэст нь бол тэр хөрөнгийн менежментийн компанийн асуудал байгаа. Тэртээ тэргүй төсөв цаана нь баталгааг нь гаргаад өгчихдөг Засгийн газрын бонд байна. Монгол банкнаас гаргадаг бондууд байна. Мөн Нийслэлээс гаргадаг, Өмнөговь аймгаас гаргадаг ч гэдэг юм уу ийм санхүүгийн чадавхтай орон нутгийн байгууллагууд, энэ төрийн захиргааны байгууллагууд, төрийн захиргааны төв байгууллагууд гэдэг юм уу ийм төрөөс гаргаж байгаа ийм баталгаатай бондыг худалдан авах үед заавал хөрөнгийн менежментийн компаниар бүгдэнгээр нь дамжуулж байж 2 хувийн шимтгэлийг тэнд үлдээх ямар хэрэгтэй юм.

Ийм учраас энэ хуулийнхаа заалтад бас энэ баталгаатай гэж үзэх ийм бүр нэр шиг нэр нэрээр нь заагаад өгч болно. Ийм тохиолдолд бол хөрөнгийн менежментийн компаниар биш шууд зах зээлтэйгээ харилцах боломжийг нь нээж өгч либералчлах, чөлөөтэй байлгах, энэ юмыг нь хийж өгөхгүй бол бүх юмыг нь ингээд баглаж боосон ийм хууль руу орчих юм бол эндээс бол их цөөхөн хэдхэн хүн л ашиг аваад гардаг шүү дээ. Энийг та бүхэн маань анхаараарай. Гэхдээ энэ асуудал бол өөрөө маш чухал. Тэгээд Аубакир сайд бас энэ хуулийн төслийг оруулж ирж байгаад баяр хүргэе. Өнөөдөр байж байгаа, өнөөдөр ингээд тэтгэврээ аваад ингээд амьдрал нь баталгаагүй болж байгаа энэ олон ахмадуудын хувьд бол энэ шинэчлэл бол ихээхэн ач холбогдолтой гэж харж байна.

88 тэрбум төгрөг цуглаад ингээд өөрсдөө сайн дураараа хийж байгаа гэсэн юм ярьж байна шүү дээ. Цаашдаа бас энэ тэтгэвэр, шимтгэл төлөгч өөрийнхөө 17 хувиасаа тодорхой хувь хэмжээг нь ингээд сангууд руу оруулчих ийм боломжийг нь л бий болгоё л гэсэн ийм санаа бас цаана нь явж байгаа гэдгийг хэлье. Ингээд Монгол Улс бол дандаа гадаадаас хөрөнгө оруулахдаа биш дотооддоо бас өөрийнхөө ийм удаан хугацаанд хөрөнгө оруулах боломж бүхий ийм сангуудыг хөгжүүлэх цаг нь болсон. Энэ хуулийн төслийг бол дэмжиж байгаагаа дахин илэрхийлье. Баярлалаа.

П.Ганзориг: Ганбатын Хосбаяр гишүүн үг хэлье.

Г.Хосбаяр: Уг нь асуулт асуух байсан чинь тэгээд хоцорчихлоо. Энэ хувийн тэтгэврийн сангийн тухай хуулийг бол дэмжиж байгаа. Одоо бол мэдээж 5 орчим аж ахуйн нэгж, сан байх шиг байна. 80 гаруй тэрбум төгрөг татчихсан байж байгаа. Тэгээд энэ ер нь бас юунд хөрөнгө оруулалт хийгдэж байгаа вэ, хаана байршиж байгаа вэ. Өндөр хяналттай байгаа гэж бодож байна. Тэгээд энэ дээр бас Санхүүгийн зохицуулах хороо бас анхааралтай байх байх. Сая Наранбаяр гишүүний хэлж байгаа санаатай бол ер нь санал 1 байгаа. Бид нар чинь саяхан хэдэн жилийн өмнө Австралийн хөгшчүүл Монголын Оюутолгойгоос ашиг хүртээд л, манай Оюутолгойн мөнгөөр зугаалаад байгаа юм яриад, баахан бид нар чинь шуугьсан шүү дээ. Тэгээд би бас судалж үзсэн юм. Гэтэл Австралийн тэтгэврийн сан бол гаднын өндөр өгөөжтэй хувьцаануудыг аваад, тэр хувьцааны өсөлтөөс ашиг хүртээд, яг тэрүүгээрээ, тэр ашгийнхаа маржаар тэр хөгшчүүлдээ заавал яг тогтсон хувь хэмжээгээр биш, бас ингээд ашиг хүртээдэг, тэтгэврийн үр өгөөж хүртээдэг ийм зүйлүүд хийдэг юм байна лээ. Тэгэхээр яг энэ шиг энэ санг ирээдүйд ингэж хөгжүүлж, ингэж удирдаж авч явах ёстой юм. Түүнээс биш бол өнөөдөр төлсөн хэдэн төгрөгөөр 10 жилийн дараа буцаагаад хувь хэмжээгээр өгөөж хүртээнэ гэвэл нөгөө мөнгөний ханшийн уналт, нөгөө инфляцаасаа шалтгаалаад л олигтой үр өгөөжгүй л юм болох гээд байгаа байхгүй юу.

Тийм учраас яг одоо тэр сангийн хөрөнгөөр тэр гаднын өндөр өгөөжтэй бид нар чинь Норвегийн баялгийн сан гээд л ярьдаг шүү дээ. Яг тэрэн шиг ингээд сангаа зөв удирдаад, өндөр өгөөжтэй тэр үл хөдлөх мөн хувьцаа, тэгээд өөр юу байдаг юм, баталгаатай Засгийн газрын бондууд энэ тэр аваад, тэгэхдээ дандаа гаднаас. Түүнээс биш дотоодын зах зээл дээрээ эргэлдээд, магадгүй энэ 80 тэрбум төгрөгөөр дотооддоо мөнгө хүүлээд байж магадгүй л дээ. Тэгэхээр ингэмээргүй байгаа юм. Жишээ нь, энэ чинь гаднын өндөр хөгжилтэй орнууд, энд өсөж байгаа эдийн засаг, дэлхийн том мөнгө эргэлдэж байгаа газруудаас бид нар яагаад мөнгө олж болохгүй гэж. Тэгээд энийг л бас сайн хуульчилж, сайн оруулж өгмөөр байна л даа. Тэгэхээр энэ дээр Санхүүгийн зохицуулах хороо бас илүү санаачилгатай, илүү судалгаатай зүйлийг оруулж ирмээр байна гэж хэлж байна.

Тэгэхгүй бол Австралийн тэтгэврийн сангийн хөгшчүүд болохоор Монголын Оюутолгойн баялгаас хувь хүртээд байдаг. Монголчууд өөрсдөө хүртэхгүй гээд л бид нар чинь ярьдаг. Тийм ээ. Яг тэрэн шиг магадгүй хэдэн жилийн дараа бид нар өөр 1 улсын хүмүүс бид нарт атаархчихсан. Үгүй ээ, тэр Монголын хөгшчүүл манай энэ баялгаас, манай энэ үл хөдлөхөөс ашиг хүртээд байна гээд бас ярианы бай болчихсон сууж байвал их сайхан байна шүү дээ. Тийм учраас энэ өндөр өгөөжтэй зах зээл, гадагшаа хандсан жоохон чөлөөтэй сэтгэж ийм юм хиймээр байна. Тэгэхгүй бол бас манай Санхүүгийн зохицуулах хорооныхон ч юм уу, манай энэ санхүүгийн салбарынхан чинь хэтэрхий эрсдэлийг тооцоод л ингээд хөдөлж чаддаггүй, юм хийж чаддаггүй. Тэгээд байгаа хэдэн төгрөгөө дотоодынхоо зах зээл дээр л эргэлдүүлээд, ингээд хүүлээд л байдаг. Энэ чинь бие биедээ л мөнгө хүүлж байгаа хэлбэр шүү дээ. Тэгэхээр жоохон тийм задгай сэтгэж, гадагшаа хөрөнгө оруулалт хийх ийм боломжийг нээж өгөх зүйл заалтыг оруулж өгмөөр байна гэдэг саналыг хэлье. Тэгээд энэ зүйлийг бол дэмжиж байгаа.

П.Ганзориг: Доржзовдын Энхтуяа гишүүн үг хэлье.

Д.Энхтуяа: Тэтгэврийн тогтолцоонд тулгамдаж байгаа асуудлуудыг шат дараатай шийдвэрлэхээр хуулийн төслүүдийг оруулж ирж байгаа Аубакир сайд болон энэ бодлогын яамны хамт олонд бас энэ хуулийн төслийг дэмжиж байгаагаа илэрхийлье.

Тэгэхээр өнөөдөр бас нэг талаасаа тэтгэврийн сан бол бас ачааллаа дагахгүй. Нөгөө талаасаа тэтгэвэр авагчид маань амьжиргааны түвшнээс доогуур орлоготой болчихоод ерөнхийдөө 2 талаас энэ тулааны цэг дээр уулзчихаад байж байна. Тэгэхээр энэ яах аргагүй шат дараатай шийдвэрлэх асуудал оруулж ирж байгаад бас дэмжээд явна.

Ер нь тэгээд энэ хувийн тэтгэврийн сангийн хуулийг хамгийн түрүүнд оруулж ирсэн нь бас зөв гэж бодож байна. Тэгэхээр дэлхийн энэ хөрөнгийн зах зээл дээр хамгийн том тоглогчид бараг 50 хувь ч билүү, 50-аас илүү хувь ч билүү энэ тэтгэврийн хувийн сангууд эзэлдэг. Тэгэхээр яг энэ дэлхийд гарчихсан, энэ хэвшсэн энэ тогтолцоог бас Монголд оруулж ирэх анхны хуулийн төслийг оруулж ирсэн байна.

Гэсэн хэдий амьдрал бас аль уже энийг чинь хэрэгжүүлээд эхэлчихсэн байна шүү дээ. 5 хувийн даатгалын сангууд байна. Тэнд бас 120, 130 мянган иргэд бас хувиараа өөрсдөө даатгуулчихсан байна гэдэг чинь энэ зах зээл байна л гэж ингэж үзэж байна. Гэхдээ энэ хуулийн төсөл дээр түрүүн бас асуултаас хоцорчихлоо.

Ерөнхийдөө энэ даатгуулагч иргэдийг хамгаалах хамгаалалт нэг талаасаа хувийн энэ сангууд маань хуулиар хамгаалагдсан үйл ажиллагаа нь хуульчлагдаад явах нь байна шүү дээ. Нөгөө талаасаа яг даатгуулагч иргэдийн маань бас баталгааг нь яаж хангах юм гэдэг дээрээ та нар бодолцоорой. Өвлүүлэх юм уу, хамтын тэтгэврийн сан гэдэг Хамтын тэтгэврийн тухай хууль гээд л байсан. Одоо бол 20 хувийг авч байгаа байх. Тэгэхээр өвлөж үлдээх тал дээр энэ даатгуулагч иргэдийн эрх ашгийг хамгаалах тал дээр бас энэ хуулийн зохицуулалт дээр ямаршуухан байдалтай байгаа в. Энийг гишүүд бас ерөнхий цаашдаа хэлэлцэгдээд явахаар бол асуух байх. Тэгэхээр энэ хамгаалалт бол аягүй чухал. Хүмүүс чинь бас мэдээжийн хэрэг энэ нэлээн мэдээлэлтэй, ингээд ирээдүйгээ бас баталгаатай болгох ийм хариуцлагатай сонголт хийж байж энэ хүмүүс хувийн даатгалын санд бас хамрагдаж байна шүү дээ. Тэгэхээр энэ хүмүүсийнхээ бас эрх ашгийг хамгаалах тал дээр нэлээн зохицуулалтууд оруулж ирэх шаардлагатай болов уу гэж би харж байна. Өнөөдөр яах вэ, ер нь тэтгэвэрт гарснаас хойш эмэгтэй хүн 55 наснаас хойш 20 жил ажиллах ийм боломжтой. Насны хувьд, манай чинь насжилт бол нэмэгдээд байна шүү дээ. Эрэгтэй хүн бол дунджаар бас 16, 17 жил ажиллах боломжтой бие бялдар, физиологийн хувьд. Одоо бол манай насжилт бол маш өндөр болчихсон. 71, 72 болчихсон байгаа юм. Тэгэхээр бас дараа дараагийн хуулийн төслүүд дээрээ одоо бол 3 сараар нэмэгдээд явж байгаа байх. Энэ тэтгэвэрт гарах насны хязгаарыг яаж тогтоож өгөх юм. Тэрийгээ бас та бүхэн энэ дараа дараагийнхаа хуулиуд дээр харж байгаа байх гэж бодож байна.

2-т нь бараг 40 хувь нь газрын доор болон хортой, халуун, хүнд, олон хүүхэдтэй, малчны, урлагийн, төмөр замын, цэрэгжүүлсэн хамгаалалтын албаны тэтгэвэр гээд ерөнхийдөө зэрэг дэвийн энэ тэтгэврүүд чинь бас өндөр тэтгэвэр авагчид бас өндөр байна шүү дээ. Тэгэхээр энэ бас дэлхийн жишгээр ямар байдаг юм. Манайх жишээлбэл 45 насанд нь цэргийн албан хаагчдыг тэтгэвэрт гаргачихдаг. Энэ хүмүүс чинь жинхэнэ ажил хийх насны бие бялдрын хувьд бас яг цэрэг дайны байдалтай ийм улс биш болохоор энийгээ бас эргэж харах шаардлагатай байдаг юм уу. Та бас тэтгэврийн шинэчлэлийн дараа дараагийн энэ хуулийн төслүүдийг оруулж ирж нэлээн бас судалгаатай ингэж явагдаж байгаа байх. Тийм учраас ер нь энэ тэтгэврийн шинэчлэлийг үе шаттай, мэдээж 1 удаагийн юугаар хийгээд ингээд цогцоор нь өөрчилдөггүй юм байна л даа. Энэ дэлхийн жишгийг харж байхад маш их асуудлууд дагуулдаг. Тэгээд дахин дахин сайжруулаад явдаг. Тэгэхээр энэ бүх

зүйл дээрээ бас эргэж харах байх гэж бодож байна. Тэгээд энэ хувийн тэтгэврийн сангийн энэ тогтолцоог оруулж ирж байгаа нь маш сайн зүйл болж байна. Тэгээд энэ .../минут дуусав/

П.Ганзориг: Даваасамбуугийн Ганбаа гишүүн үг хэлье.

Д.Ганмаа: Бараг бүх гишүүд л дэмжиж байна гэж хэлж байна. Тийм ээ. Энэ хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцоог бий болгох нь хүн амын насжилт нэмэгдэж байгаа яг одоо байгаа нөхцөл байдалд бол үнэхээр зөв чиг хандлага гэж бол үзэж байна. Бас дэмжиж байна. Гэхдээ энэ иргэдийн хуримтлалын хөрөнгийг яг зах зээлийн эрсдэлээс хамгаалах тэр механизм, бас сангийн нөгөө сайн засаглал, тэгээд шимтгэлийн ил тод байдал, түрүүн бас хүртээмжийн асуудал гээд Нара гишүүн ярьсан. Эдгээр асуудал дээр бас нэлээн анхаарах шаардлагатай санагдаж байна. Уг нь танилцуулга дээрээ бичсэн байна л даа. Энэ хувийн тэтгэврийн сангууд үүсгэн байгуулагдаад, тэгэхдээ тогтмол хяналт шалгалт хийдэггүй, засаглалын зохистой байдлыг хангасан эсэх нь тодорхой биш, үйл ажиллагаа, санхүүгийн тайлан мэдээлэл нь олон нийтэд тодорхой биш, ил тод бус энэ тэр гээд. Тэгээд бичээд яг энэ хуулиараа хийсэн өөрчлөлт, саналууд нь эдгээрийг нэг бүрчлэн тусгаж уу, үгүй юу гээд ингээд харахаар бас хэд хэдэн саналууд нэмэлтээр надад байна. Та хэд яах вэ, өөрсдөө бодоод, авахыг нь аваад, авахгүйг нь бас аваарай.

Жишээлбэл, хамгийн бага өгөөжийн босгыг тогтооно гээд байгаа. Жишээлбэл нөгөө олон улсад Америк энэ тэрд энэ босготой байдаг. Тэгээд сангууд нь хэрвээ тодорхой доод өгөөжөөс доошоо ороод эхлэх юм бол шууд зохицуулагч нь арга хэмжээ аваад, тухайн үед гялс интервенц хийгээд хамгаалалтад ордог.

2 дугаарт шимтгэл юм уу, шимтгэлийн зардлыгаа ил тод байлгах шаардлагатай байдаг. Автомат хамруулах буюу Auto-enrolment гэж нэрлэгддэг шүү дээ. Тийм механизмыг бас суулгачихдаг. Тэгэхээр хүмүүс заавал мэдээлэлтэй, боловсролтой, аягүй сайн сайн ойлгодог, эдийн засгийн тооцоогүй ч гэсэн энэ дээр магадгүй ингээд Auto-enrolment руу орох энэ боломжийг буюу хүртээмжийг нэмж өгч байгаа юм.

Дээрээс нь энэ ажил олгогчийн хөтөлбөрт ажилтныг автоматаар хамруулснаараа хамрагдалт нь бас олон нэмэгдээд, нийт сандаа ч олон нийтэд ч гэсэн улсдаа ч гэсэн хэрэгтэй байдаг. Сангийн энэ засаглалаа бас бэхжүүлэх буюу энэ хараат бус ТУЗ-ийг байгуулах, гишүүдийн төлөөллийг оруулах, магадгүй санхүүгийн боловсрол олгуулах, үнэгүй сургалт хийх, рефреш корс хийх нөгөө хүмүүсээ байнга мэдээлжүүлэх, иргэдээ эрсдэлээс хамгаалах, ингэснээрээ энэ сургалт мэдээллээ үнэгүй өгч байж энэ тэтгэврийн сан маань өөрөө илүү өгөөжтэй, илүү үр дүнтэй болох байх гэсэн ийм цөөхөн хэдэн саналуудыг хэлье гэж бодсон юм. Баярлалаа.

П.Ганзориг: Нарантуяа-Нара гишүүн үг хэлье.

М.Нарантуяа-Нара: Тэгэхээр Монгол хүн ер нь насан туршдаа хөдөлмөрлөж, хөдөлмөрлөчихөөд өтлөх насандаа л зөвхөн улсын халамжийн тэтгэвэр харах энэ байдлаар бол ядууралд өртөх магадлал маш өндөр байдаг. Энэ цаг хугацаанд бол энэ хуулийн төсөл маш зөв зүйтэй юм болж байгаа. Ялангуяа урт хугацаандаа бол энэ санхүүгийн зах зээлд хөрөнгө оруулалт татаж, иргэдэд бас өвлөгддөг баялаг үлдээх маш зөв механизм болно гэж итгэж байгаа.

Ер нь бол яах вэ хэдийгээр хэн их хөдөлмөрлөнө тэр хүн их ашиг олж, хэн их илүү төлнө, тэр хүн илүү их өгөөжийг хүртэх зарчим бол зайлшгүй ч гэсэн бид нар бас зөвхөн цөөнхөд, тэр дундаа чинээлэг цөөнхөд зориулж хууль баталж бол болохгүй. Энэ хууль бол аль болох дундаж давхаргыг хамрагдуулах, дундаж давхаргыг хамгаалах, баталгаажуулах байдлаар хэрэгжих юм бол энэ бол маш оновчтой зөв, тэгээд дээрээс нь энэ хүрээгээрээ илүү их хамгаалагдаад явах байх гэж би итгэж байна.

Тэгээд хэлэлцүүлгийн дунд ер нь хэд хэдэн зүйлүүдийг анхаараад гишүүд ч олон санаа ургуулах байлгүй. Тэгээд ямар ч л байсан хамгийн гол нь дундаж орлоготой иргэдийг сайн дураараа хувийн санд хамрагдахад төрөөс татварын бодит урамшуулал ч юм уу, буцаан авах олголтын механизмыг бий болгодог ч юм уу, тэгээд иргэдийн 20, 30 жилийн хуримтлалыг манай улсын өндөр инфляцын эрсдэлээс яаж хамгаалах, үнэгүйдүүлэхгүй байх тал дээр маш сайн анхаарах хэрэгтэй юм шиг санагдаж байна. Тэгээд энэ хувийн сан хэрвээ дампуурчихвал иргэдийн насан туршийн мөнгийг төр хэрхэн баталгаажуулах юм, хамгаалах юм гэдэг асуудлууд дээр маш сайн ажиллах хэрэгтэй байх гэж харж байна.

Тэгээд ямар ч л байсан хуулийн төслийг бол дэмжиж байгаа. Тэгээд явцын дунд илүү олон олон анзаараагүй зүйл ч байдаг юм уу, эсвэл нэмэх шаардлагатай зүйлүүдийг нэмэрлээд явъя гэж бодож байна.

П.Ганзориг: Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн үг хэлье. Эрдэнэбат гишүүн байхгүй байна. Хөххүүгийн Болормаа гишүүн үг хэлье.

Х.Болормаа: Баярлалаа. Тэгэхээр энэ хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж байгаагаа бас илэрхийлэхийг хүсэж байна. Тэгээд манай Байнгын хорооны гишүүд бүгд дэмжиж, тэгээд маш олон санал, асуултуудыг тавьж, хэлэлцэх хугацаанд бас олон асуудлуудыг гишүүдийн саналуудыг бас тусгаж оруулах нь зөв байх гэж бодож байна. Тэгээд одоогийн энэ улсын тэтгэврийн тогтолцоог олон тулгуурт хэлбэрт шилжүүлж, иргэд сайн дурын үндсэн дээр нэмэлт хуримтлал үүсгэн ирээдүйд олон эх үүсвэрээс тэтгэвэр авах боломж бүрдүүлэхэд чиглэж байна гэж би энэ хуулийн төслийг харж байна.

Тэгээд энэ хуулийн төслийн давуу талуудыг бас ард иргэддээ хэлж таниулах нь зөв болов уу гэдэг үүднээс давуу талуудыг нь би бас энд хэлэхийг хүсэж байна.

Энэ хууль батлагдсанаар дараа иргэд нэмэлт хуримтлалтай болно. Тэтгэврийн орлогын эх үүсвэр нэмэгдэнэ, хуримтлал өвлөгдөнө, санхүүгийн зах зээлд урт хугацааны хөрөнгө оруулалт бий болно, иргэдийн хуримтлалын соёл нэмэгдэнэ гэсэн ийм давуу талуудыг би бас хэлэхийг хүсэж байна.

Мэдээж сайны хажуугаар саар бас сөрөг дагавар бол дагалдаж явдаг. Тэгэхээр 1 анхаарах зүйл байгааг бас хэлэх нь зүйтэй болов уу гэж бодож байна.

Хуримтлагдсан сангийн хөрөнгийн аюулгүй байдал, төрийн хяналт, хөрөнгө оруулалтын эрсдэлийг хэрхэн зохицуулах нь уг хуулийн хамгийн чухал асуудал хэвээрээ байгааг та бүхэн бас анхааралдаа авч үзээрэй гэдгийг хэлэхийг хүсэж байна. Баярлалаа.

П.Ганзориг: Гишүүд үг хэлж дууслаа. Өнөөдөр энэ тэтгэврийн тогтолцоотой холбоотой бас хувийн нэмэлт тэтгэврийн тухай чухал хуулийн төслийг бас гишүүд хэлэлцэж, асуулт асууж, үг хэллээ.

Тэгээд өнөөдрийн байгаа манай тэтгэврийн тогтолцоо бол жилийн л 2025 оны байдлаар гэхэд улсын төсвөөс бараг 1,5 их наядын татаас дэмжлэг авч байгаа. 2026 онд бараг 1,7 орчим болж өснө гэж харагдаж байгаа. Ингээд цаашдаа явах юм бол 1 тэтгэвэр авагчид ноогдож байгаа ажиллах хүчний харьцаа өнөөдрийн байдлаар 2 харьцаатай байгаа. 2050 он гэхэд энэ маань 1/1-ийн харьцаатай болох ийм чиг хандлагатай тооцоотой харагдаж байна.

Нөгөө талдаа улсын төсвөөс өгч байгаа дэмжлэг 2050 он гэхэд яг энэ байгаа параметруудээ хөдөлгөхгүй, дундаж тэтгэвэрт гарч байгаа нас, олон төрлийн хөнгөлөлт, чөлөөлөлтөө эдлүүлээд явах юм бол бараг ДНБ-ий 5 хувьтай тэнцэх хэмжээний тоо судалгаа байна гэж хүртэл Дэлхийн банкнаас хийсэн ийм тоонууд байж байгаа. Тийм болохоор энэ хувийн нэмэлт тэтгэврийн тухай асуудал хэдий хэлэлцэж байгаа ч гэсэн бид нар энэ суурь тэтгэвэр бусад энэ тэтгэврийн тогтолцооны асуудлууддаа бас нэлээн цуг нэгтгэж ингэж ярих ёстой. Тэгээд энэ хувийн нэмэлт тэтгэврийн хууль маань бас хэлэлцээд ингээд явсан тохиолдолд гол нь хэдэн параметр хөдөлгөөд зогсохгүй, энэ олон давхаргат тэтгэврийн тогтолцооны суурь бүрдэж байгаа гэдэг их чухал ач холбогдолтой байгаа гэдгийг бас гишүүд маань хэллээ.

Ингээд гишүүд маань үг хэлээд дууссан. Тэгээд хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл бүрээр санал хураалт явагдана. Нийтдээ 13 санал хураалт явагдана. Ингээд гишүүдийг санал хураалтад бэлтгэхийг хүсье.

Санал хураалтаа эхлүүлье.

1.Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад нийт 23 гишүүн орсноос 16 гишүүн дэмжиж, 69,6 хувиар санал дэмжигдлээ.

2.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт. Санал хураалтад нийт 23 гишүүн оролцсоноос 16 гишүүн дэмжиж, санал 69,6 хувиар дэмжигдлээ.

3.Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт. Санал хураалтад 23 гишүүн оролцсоноос 15 гишүүн дэмжиж, санал 65,2 хувиар дэмжигдлээ.

4.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 23 гишүүн оролцсоноос 16 гишүүн дэмжиж, санал 69,6 хувиар дэмжигдлээ.

5.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт

явуулъя. Санал хураалтад 23 гишүүн оролцсоноос 16 гишүүн дэмжиж, санал 69,6 хувиар дэмжигдлээ.

6.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 23 гишүүн оролцсоноос 16 гишүүн дэмжиж, санал 69,6 хувиар дэмжигдлээ.

7.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад нийт 23 гишүүн оролцсоноос 16 гишүүн дэмжиж, санал 69,6 хувиар дэмжигдлээ.

8.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад нийт 23 гишүүн оролцсоноос 16 гишүүн дэмжиж, санал 69,6 хувиар дэмжигдлээ.

9.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад нийт 23 гишүүн оролцсоноос 16 гишүүн дэмжиж, санал 69,6 хувиар дэмжигдлээ.

10.Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад нийт 23 гишүүн оролцсоноос 16 гишүүн дэмжиж, санал 69,6 хувиар дэмжигдлээ.

11.Үнэт цаасны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 23 гишүүн оролцсоноос 16 гишүүн дэмжиж, санал 69,6 хувиар дэмжигдлээ.

12.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 23 гишүүн оролцсоноос 16 гишүүн дэмжиж, санал 69,6 хувиар дэмжигдлээ.

13.Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 23 гишүүн оролцсоноос 16 гишүүн дэмжиж, санал 69,6 хувиар дэмжигдлээ.

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг төсөл тус бүрээр санал хураалт явуулж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд унших гишүүнээр Аюушийн Ариунзаяа гишүүнийг томилъё.

15.21 цаг.

Ингээд дараагийн хэлэлцэх асуудалдаа оръё.

Эрүүл мэндийн даатгалын салбарын санхүүжилт, эмийн үнэ, хүний нөөц, цалингийн хөлсний талаарх Эрүүл мэндийн сайдын мэдээллийг сонсоно.

Мэдээллийг Засгийн газрын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Аубакир танилцуулна.

Т.Аубакир: Эрхэм хүндэт Улсын Их Хурлын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Бейсенээс эрүүл мэндийн салбарын санхүүжилт болон тул салбарт тулгамдаж байгаа асуудлын талаарх 4 агуулгын хүрээнд мэдээлэл сонсох саналыг ирүүлсний дагуу дараах мэдээллийг танилцуулж байна.

Эрүүл мэндийн салбар 2021 оноос эхлэн санхүүжилтийн шинэ тогтолцоонд шилжиж, Эрүүл мэндийн даатгалын санд түшиглэсэн 1 худалдан авагчийн тогтолцоог хэрэгжүүлж эхэлсэн. Үүнтэй холбоотойгоор өмнө нь улсын төсвөөс шууд санхүүжүүлдэг байсан зарим тусламж, үйлчилгээний зардлыг Эрүүл мэндийн даатгалын санд шилжүүлж, даатгалын сангийн орлоготой нэгтгэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэгдсэн багц, төлбөрийн хэмжээ, төлбөрийн аргын дагуу худалдан авах тогтолцоо бүрдсэн.

Энэхүү өөрчлөлтийн хүрээнд Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн хэмжээ нэмэгдэж, даатгуулагчдад учирч байгаа эрүүл мэндээс үүдэлтэй санхүүгийн эрсдэлийг хуваах чадамж нь дээшилж, хувь хүний халаасны төлбөр буурсан. Эрүүл мэндийн даатгалын эрүүл мэндийн санхүүжилтэд гүйцэтгэх үүрэг оролцоо нэмэгдэж, түүний хэрээр хариуцлага бас нэмэгдсэн.

Гэвч сүүлийн жилүүдэд зардлын өсөлттэй уялдсан санхүүгийн хүндрэлүүд үүсэх болсон. Тухайлбал, эрүүл мэндийн байгууллагуудын өглөг, авлагын харьцаа 2023 онд харьцангуй тэнцвэртэй байсан хэдий ч төрийн албан хаагчдын цалинг 2023 онд 40 хүртэл хувиар, 2024 оноос 8 хувиар нэмэгдүүлсэн. Мөн орон нутгийн нэмэгдлийн 40 хувийн нэмэгдэл зэрэг хүний нөөцийн зардал огцом өссөн.

Гэсэн хэдий ч эдгээр нэмэлт зардлыг нөхөх шаардлагатай санхүүжилт Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөвт бүрэн тусгагдаагүйгээс тус сан эрүүл мэндийн байгууллагуудад төлбөрийн өртэй болох нөхцөл бүрджээ. Үүний улмаас эрүүл мэндийн байгууллагууд авлагаа хугацаанд нь авч чадахгүйд хүрч, улмаар эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэгч байгууллагуудын төлбөр, НДШ, татвар болон бусад өр төлбөрүүд хуримтлагдаж эхэлсэн байна.

Эрүүл мэндийн даатгалын байгууллага 2025 оноос эхлэн үүссэн өр төлбөрөө бууруулах, сангийн санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор тусламж, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаанд төсвийн хязгаарлалт тогтоох арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж эхэлсэн. Үүний нөлөөллөөр эрүүл мэндийн байгууллагуудын үзүүлэх тусламж, үйлчилгээний хэмжээ тодорхой хэмжээнд хумигдаж, улмаар байгууллагуудын орлого буурч, өр төлбөр нь өссөн.

Эрүүл мэндийн даатгалын сан өр төлбөрөөс гарч байгаа ч эмнэлгүүдийн өр төлбөр нэмэгдэх хандлагатай байна. Өөрөөр хэлбэл эрүүл мэндийн салбарт санхүүжилт хангалттай биш байгаа. Сүүлийн жилүүдийн дараалсан цалингийн өсөлт буюу эмнэлгүүдийн зардлын өсөлт нь гол шалтгаан болж байна. Мөн 2025 онд эрүүл мэндийн байгууллагуудын өр төлбөр нэмэгдэхэд нөлөөлсөн томоохон

хүчин зүйлсийн 1 нь 2025 оны улсын төсвийн тодотголын хүрээнд төрийн албан хаагчдын орон тоог 9 хувиар бууруулж, үүнийг дагасан төсвийг 54,3 тэрбум төгрөгөөр бууруулсантай холбоотойгоор эрүүл мэндийн байгууллагуудын Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих төсвийг мөн бууруулж, гэрээ байгуулан ажилласан.

Гэвч богино хугацаанд эрүүл мэндийн байгууллагууд орон тооны цомхотгол хийх боломжгүй, мөн эмч, сувилагчаас бусад орон тоог бууруулах чиглэл өгсөн хэдий ч энэ нь хэрэгжих боломжгүй нөхцөл байдал үүссэнээс цалин, НДШ-ийн өр төлбөр энэ хэмжээнд нэмэгдэх үндэслэл болсон байна. Үүнтэй холбоотойгоор авлага, өглөгийн зөрүү үүсэж эхэлсэн. Мөн улсын эмнэлгүүдээс 10 гаруй эмнэлэг нь дээрх өр төлбөрийн дийлэнх хэсгийг эзэлж байгаа бөгөөд Эрүүл мэндийн даатгалын сангаас авлагагүйтэй холбоотойгоор тус өр төлбөр барагдах боломжгүй нөхцөл үүссэн байна. Энэ нь тухайн эмнэлгийн удирдлага, бүтэц зохион байгуулалт, менежменттэй холбоотой бөгөөд энэ чиглэлд Эрүүл мэндийн яамны зүгээс холбогдох хяналт шалгалтыг оруулах, бүтэц зохион байгуулалтыг оновчтой болгох, үр ашгийг нэмэгдүүлэх, өр төлбөрийг бууруулах төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Эрүүл мэндийн даатгалын санд 2022-2024 онуудад тайлангаар баталгаажсан нийт 316,8 тэрбум төгрөгийн хуримтлагдсан өр төлбөр үүссэн бөгөөд 2025 онд санхүүжилтийн зохицуулалт, бодлогын арга хэмжээ хэрэгжүүлсний үр дүнд 2025 оны жилийн эцсийн байдлаар нийт өр төлбөр 198,3 тэрбум төгрөг болж 118,5 тэрбум төгрөгөөр буурсан байна. Эрүүл мэндийн сайдын багцын эрүүл мэндийн байгууллагууд 2025 оны жилийн эцсийн байдлаар 141,1 тэрбум төгрөгийн авлагатай гарсан бөгөөд 217,7 тэрбум төгрөгийн өртэй гарсан байна. Үүний 61,9 тэрбум төгрөг нь татвар болон НДШ-ийн өр төлбөр бол 130,2 тэрбум төгрөг нь эм бэлдмэлийн зардлын өр байна. 2026 оны 5 дугаар сарын байдлаар 239,9 тэрбум төгрөгийн өртэй гарсан бөгөөд 86,5 тэрбум төгрөг нь татвар болон НДШ-ийн өр төлбөр бол 124,1 тэрбум төгрөг нь эм бэлдмэлийн зардлын өр байна.

Дээрхээс үзвэл 2026 оны эхний хагас жилийн байдлаар өмнөх онтой харьцуулахад татвар болон НДШ-ийн өр 24.6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь 2026 онд үндсэн цалинг Засгийн газрын 2025 оны 224, 225, 2026 оны 135 дугаар тогтоолоор нэмэгдүүлэх шийдвэр гарсантай холбоотой байна.

Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагуудад олгосон санхүүжилтийн хувьд орон нутгийн 34, нийслэлийн 39, эрүүл мэндийн байгууллагуудад 2023 онд 839,4 тэрбум төгрөг, 2024 онд 1,1 их наяд төгрөг, 2025 онд 1,2 их наяд төгрөг, 2026 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 532,4 тэрбум төгрөг олгосон байна. Эдгээр тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хүрээнд эрүүл мэндийн салбарт авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай Засгийн газрын 2026 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 134 дүгээр тогтоолыг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Уг тогтоолын хүрээнд эрүүл мэндийн байгууллагын зохион байгуулалт, менежмент, үр ашгийг сайжруулж, санхүүжилтийг ажлын гүйцэтгэл, үйл ажиллагааны үр дүнтэй уялдуулах, цалин урамшууллын тогтолцоог боловсронгуй болгох, зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтыг шинэчилж, эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэх, Эрүүл мэндийн даатгалын сангийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Мөн анхан шатны тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, шатлал хоорондын уялдааг сайжруулж, хүний нөөцийн хүрэлцээг нэмэгдүүлж, эмч, сувилагчийн тоог хүн амд ногдох зохистой түвшинд хүрэхээр холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.

Лавлагаа шатлалын эмнэлгүүдэд төвлөрсөн ачааллыг бууруулах зорилгоор шатлалын бодлогыг нарийвчлан тодорхойлж, үйлчилгээний давхардлыг арилгах, бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүний үр дүнд анхан шатыг алгасаж тусламж үйлчилгээг авдаг 70 хувийн урсгалыг үе шаттай бууруулах, нөөцийн үр ашигтай хуваарилалтыг бий болгох боломж бүрдэнэ.

Эрүүл мэндийн санхүүжилтийн шинэчлэлийг эхлүүлснээс хойш Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээг Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2020 оны 13 дугаар тогтоолоор баталсан ба 2022 оны 11 дүгээр тогтоолоор шинэчлэн баталж, одоо мөрдөж байна. Тус 11 дүгээр тогтоолын дагуу 156 өвчний үед хэрэглэгч 651 худалдааны нэршлийн эмийг 30, 50, 70, 100 хувиар хөнгөлөлт үзүүлж байна. Эрүүл мэндийн даатгалаар хөнгөлөлттэй олгох эмийн жагсаалт гарах тухайн үед бүртгэлтэй байсан хэдий ч бүртгэлийн хугацаа дууссан, бүртгэлийн хугацаанд импорт хийгдээгүй зэрэг шалтгаантай эмийн судалгааг хийж, зохицуулалтын арга хэмжээ авахаар ажиллаж байна.

Монгол Улс нийт хэрэглэж байгаа эмийнхээ 20 гаран хувийг дотоодын 30 орчим үйлдвэр үйлдвэрлэн, 80 орчим хувийг импортоор авч байна. Эдгээрээс зөвхөн эм үйлдвэрлэх чиглэлтэй 20 үйлдвэрийн 10 үйлдвэр нь эм үйлдвэрлэлийн зохистой дадал, GMP шаардлага хангаж, батламж авсан ба дотоодын нийт эмийн үйлдвэрлэлийн 90 хувийг эм үйлдвэрлэлийн зохистой дадлын шаардлага хангасан үйлдвэрүүдэд үйлдвэрлэж байна.

Цар тахлын нөхцөл байдал, дэлхий дахины дайны нөхцөл, тээврийн үнийн өсөлттэй холбоотойгоор дэлхийн зах зээлд эм, эмнэлгийн хэрэгсэл, түүхий эдийн үнэ тасралтгүй өссөөр байна. Монгол Улсын хүн амын тоо цөөн, хэрэглээ хязгаарлагдмал байдлаас шалтгаалан зарим нэрийн эмийг бага тоо хэмжээгээр гадаадын улсад үйлдвэрлэгч нар эм, эмнэлгийн хэрэгслийн нийлүүлэхгүй байгаагаа эмийн тасалдал үүсэх, цаашлаад үнэ нэмэгдэх шалтгаан болж байна гэж үзэж байна.

Мөн эрүүл мэндийн байгууллагууд худалдан авсан эм эмнэлгийн хэрэгслийн үнийг тухай бүр ханган нийлүүлэх байгууллагад буцааж төлөхгүйгээр аж ахуйн нэгж бүрд он дамнасан авлага үүссэнээр импортын захиалга хийгдэхгүй болж, эм, эмнэлгийн хэрэгсэл тасалдаж, үнийн нэмэгдэл гарах нөхцөл болж байна.

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.8 дахь хэсэгт заасны дагуу зайлшгүй шаардлагатай эмийн бөөний болон жижиглэнгийн үнийн нэмэгдэх хувь хэмжээний хязгаарын төслийг боловсруулан холбогдох байгууллагаас санал авч боловсруулж байна. Эрүүл мэндийн салбар хүний нөөцийг мэргэшүүлэх чиглэлээр төгсөлтийн дараах үндсэн мэргэжлийн сургалтад 2024-2025 онд 1957 эмч, төрөлжсөн мэргэжлийн сургалтад 810 их эмч, эм зүйч, 1517 сувилагч, эмнэлгийн мэргэжилтэн, мэргэжил дээшлүүлэх сургалтад 1308 их эмч, эм зүйч, 421 сувилагч, эмнэлгийн бусад мэргэжилтэн суралцсан байна.

2026 оны эхний хагас жилийн байдлаар төрөлжсөн мэргэжлийн сургалтыг 175 их эмч, эм зүйч, 6 сувилагч төгссөн бөгөөд мэргэжил дээшлүүлэх сургалтыг 2 их эмч, 62 сувилагч, эмнэлгийн бусад мэргэжилтэн төгссөн. Мөн 2026 оны эхний хагас жилийн байдлаар төрөлжсөн мэргэжлийн сургалтад 362 их эмч, эм зүйч, 434 сувилагч, эмнэлгийн бусад мэргэжилтэн суралцаж байгаа бол мэргэжил дээшлүүлэх сургалтад 397 их эмч, эм зүйч, 50 сувилагч, эмнэлгийн бусад мэргэжилтэн суралцаж байна.

Эрүүл мэндийн салбарын ажилтнуудын цалин хөлсийг нэмэгдүүлэх хүрээнд Монголын эрүүл мэндийн ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбоо, Монголын хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын нэгдсэн холбоо хоорондын эрүүл мэндийн салбарын 2024-2026 оны хамтын нэмэлт хэлэлцээрийг байгуулсан. Тус нэмэлт хэлэлцээрт эрүүл мэндийн салбарын эмч ажилтнууд ТҮМ, ТҮ, ТҮМ үндсэн цалинг 2026 онд багтаан 3 сая төгрөгт хүргэх ба 2026 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 30 хувь, 2026 оны 8 дугаар сарын 1-ний өдрөөс 9 хувь, 2026 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс 9 хувь, 2026 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс 9 хувь, 2026 оны 11 дүгээр сарын 1-ний өдрөөс 9 хувь, 2026 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс 9 хувь тус тус нэмэгдүүлж, албан тушаалын үндсэн цалинг Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор баталсан албан тушаалын цалингийн доод хэмжээнээс нийт 75 хувиар нэмэгдүүлэхээр тусгагдсан. 2026 оны 5 дугаар сарын байдлаар эрүүл мэндийн салбарын ажилчдын үндсэн цалинг 1-4 дүгээр сард 30 хувиар нэмэгдүүлж, нэмэгдэл цалинг өмнөх түвшинд царцаан хэрэгжүүлсэн бол 2026 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс үндсэн цалинг Засгийн газрын 2026 оны 135 дугаар тогтоолын дагуу тогтоож, нэмэгдэл цалинг нэмж тогтоосон цалингаас тооцож олгож эхэлсэн. Тоон үзүүлэлтээр эмч, сувилагч, бусад албан хаагчдын үндсэн цалинг нэмэгдүүлсэн шийдвэрийг өмнөх үндсэн цалинтай харьцуулж үзвэл эмчийн тухайлбал ТҮМ6 зэрэглэл үндсэн цалин 2025 онд 1 сая 559 мянга .../минут дуусав/

П.Ганзориг: Нэмэлт минут өгье.

Т.Аубакир: 1 сая 559 мянган төгрөг байсан бол 2026 оны 1 дүгээр сараас 2,026,700 төгрөгт хүрч, 467 мянган төгрөгөөр өссөн бол сувилагчийн ТҮМ 3 дугаар зэрэглэл үндсэн цалин 1 сая 347 мянган төгрөгөөс 1,751,100 төгрөгт хүрч үндсэн цалин 404 мянган төгрөгөөр өссөн байна.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

П.Ганзориг: Мэдээлэлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Бейсен гишүүний уг асуулга тавигдаад, Байнгын хороогоор бас яаралтай хэлэлцүүлчихье гээд мэдээллийг нь 2, 3 удаа товлосон. Тэгээд асуулга, мэдээлэл хүссэн гишүүн маань бас гадаад томилолттой байгаад хойшилсон. Сая дахиад сайд нь гадагшаа явж таарсан. Тэгээд ингээд хойшлоод байх юм бол удаашраад байгаа учраас Байнгын хорооны даргын хувьд олон асуудал нь Байнгын хороо дээр хүлээгдэж байгаа учраас хойшлуулалгүйгээр оруулж байгаа шүү. Тэгээд холбогдох хуулийн дагуу Засгийн газрын гишүүн танилцуулах ёстой. Тэгээд Аубакир сайд танилцуулаад, хариултыг нь Төрийн нарийн бичгийн дарга болон холбогдох албаны хүмүүс ажлын хэсгээс хариулаад явна.

Би ажлын хэсгийн гишүүдийг товч та бүхэнд танилцуулъя.

Яах вэ гишүүдээс саналууд гарч байх шиг байна. Бейсен гишүүн өөрөө мэдээлэл хүссэн хүсэлт явуулсан. Тэгээд би хүсэлт явуулсан гишүүнээс өөрөөс нь сайд нь байхгүй юм байна. Ирэх 7 хоногт явуулах уу гэсэн Батшугар сайд өөртэй нь бас уулзсан гэсэн. Тэгээд өмнөх 7 хоногт тавьчихсан байсан. Бейсен гишүүн өөрөө байхгүй гээд хойшлуулсан. Гадаад томилолттой гээд. Тэгээд одоо сайд нь байхгүй гээд хойшлуулаад байна. Тэгэхээр уг асуудлыг хойшлуулаад байвал хойшлуулаад байна. Зүгээр ииний хувьд шуурхай явах ёстой гэдэг үүднээс энэ хуваарьд нь тавиад батлуулаад байгаа юм.

2-т та бүхэн хэлэлцэх асуудалтай холбоотой санал байвал дэгийн дагуу би түрүүн 2 асуудал та бүхэнд танилцуулсан. Тэгээд хэлэлцэх асуудал дээр хойшлуулах санал байсан бол тэнд хэлээд явах ёстой. Тэгэхээр эцсийн асуудал батлагдчихсан учраас энийгээ бас сонсоод л явна гэсэн үг. Тэгээд саяын та нар хуралдаа орж ирээд цагтаа суугаад энд төлөөлөл нь байгаа юу гэдгээ асуугаад ингээд яв л даа. Эхлээд би ажлын хэсгийн бүрэлдэхүүн танилцуулаад, тэгээд горимын санал гаргачих. Тэгээд олонх нь дэмжих юм бол хойшлуулъя.

Тэгэхдээ гишүүд ээ, нэг юмыг та бүхэн бас өөрсдөө бас хариуцлагатайгаар, санаачилгатайгаар оролцоорой. Энэ аягүй олон асуудал нь Байнгын хороон дээр овоорчхоод байгаа. Аль болох олон хууль, асуудлыг хэлэлцүүлчихье гээд ингээд тавиад байдаг. Тэгэхээр хуваарьт оруулахаар гишүүд нь өөрсдөө байхгүй болчихно. Тэгээд гишүүд нь ирээд тавихаар сайд нь байхгүй болчихно. Ингээд нөгөө хонх нь дуугарахаар дамар нь таг, хоёулаа дуугарахаар лам нь таг гэдэг шиг ингээд асуудлууд хойшлуулаад, ажил явуулахгүй тэр байхгүй бол энийг хэлэлцэхгүй гээд байх юм бол энэ ажлууд чинь явахгүй. Тэгээд сайдаа орлоод төлөөлөөд сууж байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүн нь байж байна. Тэгэхээр горимын санал гаргаад, гишүүд олонхоороо өөрсдөө шийдээд яв. Дараа нь сайд нь байх үед нь хэлэлцье гэж та бүхэн олонхоороо шийдэж байгаа бол болох юм байна. Тэгэхээр Мөнхсайхан гишүүн горимын санал гаргах уу. Мөнхсайхан гишүүн горимын санал гаргая.

Т.Мөнхсайхан: Энэ эрүүл мэндийн талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг сонсоход сайд нь байвал их сайн байна. Сайдад нь хүргэх, хэлж ярих, үнэн бодит мэдээллээр нь хангах зүйл бас гишүүдэд байна. Тийм учраас дараа 7 хоногт сайдыг байх үед нь уг мэдээлэлтэй холбоотой саналд асуулт хүсэлтээ хэлж ярьгагдэг горимын санал гаргаж байна. Го

П.Ганзориг: Горимын санал гаргасантай холбогдуулан Бейсен гишүүн үг хэлнэ.

Б.Бейсен: Гишүүддээ өдрийн мэндийг хүргэе. Тэгээд энэ асуудлыг тавьж байгаа маань энэ улсын клиникийн эмнэлгүүд, 9 дүүргийн нэгдсэн эмнэлэг, аймгуудын нэгдсэн эмнэлгийн өр зээл хэрээс хэтэрсэн. Тэгээд л энийг дарахгүй бол улсын эмнэлгээ нураачих гээд байна бид нар. Энэ дээр чинь бас нэг юу байгаа. Би өнгөрсөн 7 хоногт Засгийн газрын хэлэлцээрийн дагуу гадаад томилолтоор явсан. Нөгөө талаар шүлхийн вакцины асуудлаар гадаадад яваад, энэ хойшлогдсон байсан. Тийм учраас энэ дээр бас Мөнхсайхан гишүүний санал байна. Батшугар сайд болохоор би Солонгос улс руу яваад хагалгаанд орох юм. Хадаас авхуулах юм гэсэн ийм асуудал байсан.

Нөгөө талаар нэг ярих юм байна. Энэ дээр бас нэг дутагдалтай юм байгаа юм. Энэ Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвөөс хувийн эмнэлгүүд маш ихээр өндөр өртөгтэй оношийн хамаарлын бүлгийн багцаас юу авч байгаа. Тэгээд дараа

хойшлуулбал энэ хувийн эмнэлгүүдийн Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжиж байгаа юуг нь бас тодорхой гаргаж ирэх ёстой. Уг нь тоог нь хэчнээн тэрбумыг авсан юм. Тэрийг гаргаж ирэхгүй бол Эрүүл мэндийн сайд бол түрүүн телевизээр мэдээлэл өгөхдөө Эрүүл мэндийн даатгалын са, эмнэлгүүд ямар ч өргүй боллоо гэж хэлсэн. Одоогийн энэ юм харж байхад нийт өрийн хэмжээ энэ дээр чинь хэдэн тэрбум гэж байна. Эмнэлэг болгоныг гаргасан байна. Нийт өр 238 тэрбум байна. Тэгээд цалин, НДШ нь 86 тэрбум, эм ер нь 124 тэрбум гэж байна, бусад гээд 29 тэрбум байж байна. Тийм учраас эмнэлгүүд эмгүйгээр явахгүй шүү дээ. Дайнд сум буугүйгээр байлдахгүй шүү дээ. Тэрэнтэй адилхан юм байгаа байхгүй юу. Хувийн эмнэлгийн санхүүжилтийн энэ өндөр өртөгтэй оношны хамаарлын бүлгээс хувийн эмнэлгүүд маш их өндөр Эрүүл мэндийн даатгалаас санхүүжиж байгаа. Энийг зогсоож байж энэ өрийг дарж, улсын эмнэлгээ босгож ирэхгүй бол энэ эмнэлэг босохгүй шүү.

П.Ганзориг: Сая Бейсен гишүүний хэлсэн саналыг бас Эрүүл мэндийн яам, Ерөнхий газрынхан, яамныхан бас бичиж тэмдэглэж аваад, дараагийн хойшлуулаад хэлэлцэх үед тодорхой тэр хувийн хэвшлийн эмнэлгүүдийн авч байгаа санхүүжилт, өр авлага, тооцоог дэлгэрэнгүй танилцуулах бэлтгэлээ хангаж орж ирнэ шүү.

Ингээд Мөнхсайхан гишүүний гаргасан горимын саналын дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.3-д заасны дагуу “хуралдаанаар 1 асуудлыг хэлэлцэж эхэлсэн боловч түүний хэлэлцүүлгийг горимын саналаар хойшлуулсан тохиолдолд хуралдаан даргалагч дараагийн асуудлыг хэлэлцүүлнэ.” гэж заасны дагуу санал хураалтыг явуулъя. Тэгээд санал хураалтад бэлтгье гишүүд.

Мөнхсайхан гишүүний гаргасан горимын саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад нийт 23 гишүүн оролцсоноос 15 гишүүн дэмжиж, санал 65,2 хувиар дэмжигдлээ.

Ингээд Эрүүл мэндийн даатгалын салбарын санхүүжилт, эмийн үнэ, хүний нөөц, цалингийн хөлсний талаарх мэдээлэл сонсох байсан. Энэ асуудлыг хойшлууллаа.

Өнөөдрийн Байнгын хорооны хурлаар хэлэлцэх асуудал дууссан тул Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдааныг өндөрлөснийг мэдэгдье. Хуралдаандаа бас идэвхтэй ирж оролцсон нийт гишүүддээ бас талархал илэрхийлье.

15.40 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ